

**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**2022.01.03**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /сая.төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2021 оны Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
<b>СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 1. ГАМШИГ, НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ</b>							
1.	Төвийн Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөөнд тодотгол хийж, шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг бий болгож ажиллана.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Эрүүл мэндийн улсын алба, ТУТ-ны тодотгосон төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөг тухай бүр тодотгож ажилласан.	Төлөвлөгөөг шинэчлэн баталж, төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна.	<p>ЭМЯ, ЭМУА-наас Ковид-19 халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг тодотгох бүрт төвийн ТУТ-ны төлөвлөгөөг уялдуулан тодотгон батлуулж хэрэгжүүлж ажилласан. Үүнд:</p> <p>1. 02 дугаар сарын 08-ны өдөр Бүх нийтийн бэлэн байдлын үед төвийн үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах төлөвлөгөө</p> <p>2. 04 дүгээр сарын 29-ний өдөр ЦССҮТ-ийн тохиолдлын удирдлагын тогтолцооны хариу арга хэмжээний тодотгосон төлөвлөгөө</p> <p>Эрүүл мэндийн яаманд ТУТ-ны төлөвлөгөөний хэрэгжилтийг 7 хоног бүрийн 5 дахь өдөр бүр нийт 53 удаа, Эрүүл мэндийн сайдын 5 дугаар албан даалгаварын явцын тайлан, ТУТ-ны штабын коронавируст цар тахлын үед авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээний нэгтгэсэн тайлан, Эрүүл мэндийн сайдын 9 дүгээр албан даалгаварын хэрэгжилтийн тайланг тус тус гарган хүргүүлсэн байна.</p> <p>Захирлын А/03 дугаар тушаалын дагуу төвийн зарим алба, тасгуудын ажлын тусгай горимд ажиллах хуваарьт шилжүүлэн ажиллаж 02 дугаар сарын 10-ны өдөр А/05 дугаар тушаал Билгийн тооллын цагаан сарын амралтын</p>	100 %

						<p>болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжсэн өдрүүдэд Төвийн үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах, цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг тасралтгүй зохион байгуулах зорилгоор Ажлын тусгай горимоор ажиллах ажилтны хуваарь, Хариуцлагатай эргүүл дуудлагаар ажиллах ажиллагсдын хуваарь, Лавлагаа шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх ажиллагсдын хуваарь, Бүх нийтийн хөл хорионы үед дайчлагдан ажиллах багуудыг тус тус батлан гаргаж төвийн хэвийн үйл ажиллагаа, цус цусан бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг ханган ажиллаж Эрүүл мэндийн сайдын тушаал шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан.</p> <p>Төвийн гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед ЦССҮТ-н ажиллах журмыг Ерөнхий захирлын 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/17 тушаалаар шинэчлэн төвийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийсэн. Журманд гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед түргэн цуглах ажиллагсдын хаяг, утасны жагсаалт, дохио хүргэх хуваарилалтыг шинэчлэн тодотгол хийсэн. Тодотгосон төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлж ажилласан.</p> <p><b>Хавсралт. Батлагдсан төлөвлөгөө</b></p>	
2.	<b>ТЭМТББ 1.5.1.1:</b> Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед шаардагдах нөөцийн хэрэглээг тооцох, төлөвлөх, хяналт тавьж бэлэн байдлыг хангах, шуурхай дайчлах,	-	Бүрдүүлсэн нөөцийн хэмжээ	Коронавирст халдвар Ковид-19 цар тахлын үед ажиллах, төлөвлөгөө боловсруула н тухай бүр тодотгож,	Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед шаардагдах 1 сарын нөөцийг	Төвийн гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед шаардагдах нөөцийн хэрэглээг тооцон нөөцийн бүрдүүлэлт, зарцуулалтанд хяналт тавьж, шаардлагатай нөөцийн 1 сараас багагүй нөөцийг бүрдүүлж ажилласан. Burtgel.mohs.mn цахим системд нөөцийн үлдэгдэл,	100 %

	хариу арга хэмжээг авах чадавхийг бэхжүүлнэ.			хэрэгжилтийг ханган үйл ажиллагааны бэлэн байдлыг хангасан.	бүрдүүлсэн байна.	<p>орлого, зарлага, хүний нөөцийн мэдээллийг 7 хоног бүр шинэчлэн бүртгэж мэдээлж ажилласан. 12 сарын 23-ны байдлаар <a href="http://burtgel.mohs.mn">burtgel.mohs.mn</a> цахим системд хамгаалах хувцас хэрэгсэл, цус цусан бүтээгдэхүүний үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд: Эм эмнэлгийн хэрэгсэл,</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нэг удаагийн малгай 354 ш</li> <li>• Нэг удаагийн халад 5199 ш</li> <li>• Эмнэлгийн нэг удаагийн амны хаалт 46975 ш</li> <li>• Үзлэгийн бээлий 73110 хос</li> <li>• Гутлын улавч 3130 хос</li> <li>• Комбинзон 667 ш</li> <li>• Хормогч 23 ш</li> <li>• Нарийн шүүлтүүртэй амны хаалт N95 2551 ш</li> <li>• Нүүрний хаалт 150 ш</li> <li>• Ахуйн бээлий 109 хос</li> <li>• Усны гутал 3 хос</li> <li>• Аюултай хог хаягдлын уут 4408 ш</li> </ul> <p>Оношлуурын нөөц Ковид-19 антиген тест 900 ширхэг, PCR орчин 200 ширхэг тус тус үлдэгдэлтэй байна. Улаан эсийн бүтээгдэхүүн 1518 нэгж, Хөлдөөсөн шинэ сийвэн 8034 нэгж, К-Сийвэн 8558 нэгж, Криопреципитат 212 нэгж ЦЦБ-ий үлдэгдэлтэй байна.</p> <p>Бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн бэлэн байдлыг хангаж Мешок-10ш, гудас-7ш, газын плитека-2ш, газ-8ш, ус буцалгагч-1ш, тогоо, шанага-1ш, лед гэрэл-4ш, цамц-10ш, 4 халдвар илрүүлэх түргэвчилсэн оношлуур /ДОХ-3 хайрцаг, Тэмбүү-3 хайрцаг, В вирус 4 хайрцаг, С вирус 4 хайрцаг/ тус тус нөөцөлсөн байна.</p>	
3.	<b>ТЭМТББ 1.5.1.2.</b> Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед тусламж, үйлчилгээ үзүүлэх цусны нөөц төвийн бэлэн	-	Шаардлагатай үе ашиглах цусны нөөц төв	Сүхбаатар цус цуглуулах төв дээр гамшгийн үеийн нөөц төвийг	Цусны нөөц төв ажиллахад шаардлагатай баримт бичгүүдийг шинэчлэн	ОБЕГ-ын Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газартай хийсэн гэрээг дүгнэж, шинэчилсэн. Мөн улсын нөөцөд бараа, материал худалдан авах гэрээ байгуулан гэрээний хэрэгжилтийг ханган	100 %

	байдлыг хангаж ажиллана.			зохион байгуулан, тоног төхөөрөмж, хэрэгсэл, цус, цусан бүтээгдэхүүн ий нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна.	батлуулж, хөлдөөсөн шинэ сийвэнгийн нөөцийг бүрдүүлсэн байна.	ажилласан. Гэрээний дагуу ЦЦБ-ний нөхөн сэлгэлтийг 2021 оны 4, 10, 12 саруудад хийж баримтжуулсан. Мөн Төвийн нөөцийн хөлдөөсөн шинэ сийвэн, К сийвэнгийн нөхөн сэлгэлтийг 2021 оны 4, 5, 9 дугаар сард нийт 3 удаа хийж сийвэнгийн бүтээгдэхүүний тооллого хийсэн. Гамшгийн нөөц төвийн ЦЦБ-ний хадгалалтанд өдөр бүр хяналт тавьж ажиллаж байна. Цусны нөөц төвийн бэлэн байдлыг хангаж стандарт ажиллагааны заавар, тоног төхөөрөмж ажиллуулах заавар, журам, гарын авлагыг шинэчлэн баталгаажуулсан.	
--	--------------------------	--	--	--	---	--	--

**СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 2. ХҮН АМ, ЦУСНЫ ДОНОРТ СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА ХИЙХ, ЦУСНЫ ДОНОРЫГ АЛДАРШУУЛАХ, УРАМШУУЛАХ**

4.	Сошиал медиа маркетинг ашиглан шинэ контент бүтээх, иргэд, цусны донорт амьдралын зөв дадал хэвшлийн талаар мэдээ мэдээлэл хүргэнэ.	-	Шинээр бүтээсэн контентийн тоо Олон нийтэд хүргэсэн МСС-ны тоо	Цахим орчинд 80 дээш мэдээлэл байршуулсан.	Цахим орчинд 250 мэдээ, мэдээллийг байршуулж олон нийтэд хүргэсэн байна.	ДЭМБ, Төр.мн сайт, JCI капитал байгууллагатай хамтран 7 шинэ контентуудыг бүтээж сошиал орчинд байршуулан цусны донорын сургалт, сурталчилгаа хийсэн. 1. Статистикийн үндэсний хороотой Цусны донор статистикийн нүдээр инфографик-1, ДЭМБ-ын санхүүжилтээр цусны донорын үйлсийг сурталчлах сургалт сурталчилгааны 7000 материал хийлгэж ашигласан. 2. 2021 оны 1 улиралд “Донор та баатар” фейсбүүк групп шинээр нээж 2021 оны жилийн эцэст гишүүнчлэлийн тоо 7700, “Амьдрал бэлэглэе” хуудасны 10250 лайкын тоо 10,700 лайк болж нэмэгдсэн. Мэдээлэл хүрсэн хүний тоо-74200 буюу 226 хувиар нэмэгдсэн. Харьцсан хүний тоо 469 буюу 162 хувиар, мэдээлэлд өгсөн лайкын тоо 82 хувиар нэмэгдсэн. 3. Донор та баатар” фейсбүүк групп, “Амьдрал бэлэглэе”, пейж хуудсаар нийт цусны донорын сургалт	100 %
----	---	---	--	--	--	---	-------

					<p>сурталчилгаатай холбоотой 6 нэр төрлийн видео контентийг 24 удаа, ЦССҮТ-ийн 5 минутын хугацаатай баримтат видеог 12 удаа, донорын сурталчилгааны постер 27 удаа, алдаршуулалтын талаар мэдээлэл 34 удаа, байгууллага хамт олны цусаа өгсөн тухай мэдээллийг нийт 27 удаа байршуулсан. Нийт 100 мэдээ байршуулсан. Төвийн вэб хуудсанд нийт 18 мэдээ байршуулсан.</p> <p>1. Цус сэлбэлт судлалын үндэсний төв пэйж хуудсын дагагчидын тоо оны эхэнд 30519 байсан бол 39648 болж 29,9 хувиар өссөн. Нийт пэйж хуудас дагагчидын 70% эм, 30% нь эрэгтэй дагагчид байна.</p> <p>2. 2021 онд 5721 мэссэж илгээж хариу авсан. Пейж хуудсанд энэ онд зурган пост 11,374, Линк шэйрлэсэн 5812, Энгийн пост 5234, Видео пост 3247 тус тус оруулж сургалт суртчилгаа хийсэн байна.</p> <p>3. Нийтийн тээвэр үйлчилгээний автобусны бариул, орон сууцны лифтний дэлгэцээр цусны донорын сургалт сурталчилгааг зохион байгуулж ажилласан.</p>	
--	--	--	--	--	--	--

5.	Сайн дурын идэвхтэн, сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөр шинэчлэн боловсруулж, сургалт зохион байгуулна.	1.0	Сайн дурын идэвхтэн 60, сургагч багш 15-аас доошгүй бэлтгэгдсэн байна. Сургалтын тайлан.	2020 онд сайн дурын идэвхтэн 60, сургагч багш 15 бэлтгэгдсэн.	Шинэчилсэн хөтөлбөрийн дагуу сайн дурынханыг чадавхжуулах сургалт 4 удаа, сургагч багшийн сургалт 2 удаа зохион байгуулсан байна.	МУЗН-тэй хамран сайн дурын идэвхтэн, сургагч багш бэлтгэх хөтөлбөрийг шинэчлэн, 5 удаагийн сургалтаар 205 идэвхтэн, 3 удаагийн сургалтаар 29 сургагч багш бэлтгэсэн байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Налайх хэрэглэгчдэд үйлчлэх төвийн ажилтнуудад цахим сургалт зохион байгуулж НД, ЦТСТӨХК-ий нийт 44 ажилтан, албан хаагчид хамрагдаж цусны донорын сайн дурын идэвхтэн, Улаан Загалмайн хороон дарга, арга зүйчийг сургагч багшаар бэлтгэсэн.</li> <li>• Сайн дурынханыг чадавхжуулах 6 өдрийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар Улаанбаатар хотын 6 дүүрэг бүрээс 1 арга зүйч, 9 сайн дурын идэвхтэн нийт 62 хүн сайн дурын идэвхтэн, арга зүйчийг хамруулан чадавхжуулж, 6 арга зүйчийг сургагч багшаар бэлтгэж гэрчилгээ олгосон.</li> <li>• ОУ-ын Ротаригийн 3450-р дүүргийн 9,10 бүсийн захирагчтай хамтран ажиллах санамж бичиг байгуулж, Rotary Club of Zuunmod-н 14 Ротаричуудад төвийн үйл ажиллагааг танилцуулж сайн дурын ажилтнаар бэлтгэсэн.</li> <li>• “Сайн дурын авлагагүй цусны донорын эгнээг өргөжүүлэхэд сайн дурын идэвхтнүүдийг чадавхжуулах” нь цахим сургалтыг МУЗН-ийн орон нутгийн 21 салбарын арга зүйч нарт зохион байгуулан гэрчилгээ олгосон.</li> <li>• БЗД-ийн УЗХ-той хамтран донорын эгнээг өргөжүүлэх, донорын сургалт сурталчилгааг хэрхэн зохион байгуулах сургалтыг төвийн эмч, сувилагч нар ажлын байран дээр зохион байгуулж ирээдүйн 64 өсвөр үеийн улаан загалмайчдыг донорын үйлсийг сурталчлах сайн дурын ажилтнаар бэлтгэсэн.</li> </ul>	100 %
----	--	-----	--	---	---	---	-------

					<ul style="list-style-type: none"><li>• Цусны донорын талаарх ерөнхий ойлголт, Цусны донорын сургалт сурталчилгааг хэрхэн зохион байгуулах сэдвээр тус бүр 30 минутын сайн дурынхан болон сургагч багш бэлтгэх онлайн сургалтын хөтөлбөрийг шинэчилсэн.</li><li>• АШУҮИС-ийн бүрэлдэхүүн сургуульд нийт 9 удаа явуул зохион 3000 гаруй хүнд угтуулан сургалт хийж 1267 оюутан цусаа бэлэглэсэн. МУИС-ийн аян 4 өдөр зохион байгуулагдаж нийт 200 оюутан цусаа бэлэглэсэн.</li><li>• Угтуулан сургалт сурталчилгааг нийт 53890 гаруй хүнд аман болон цахим хэлбэрээр зохион байгуулан 26321 донор цусаа бэлэглсэн.</li></ul>	
--	--	--	--	--	---	--

6.	Хүн амын эрсдэл багатай бүлгээс сайн дурын, авлагагүй цусны донорын эгнээг өргөжүүлнэ.	10.8	Шинээр элсүүлсэн цусны донорын тоо	2020 онд 10228 иргэнийг сайн дурын авлагагүй цусны донорын эгнээнд элсүүлсэн байна.	Хүн амын эрсдэл багатай бүлгээс 10500 цусны шинэ донорыг элсүүлж цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулсан байна.	МУЗН-тэй хамтран цусны донорын сургалт сурталчилгааг олон талт хэлбэрээр зохион байгуулсны дүнд хүн амын эрсдэл багатай бүлгээс 9572 цусны шинэ донорыг элсүүлж цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулсан байна. 2021 оны шинэ донор элсүүлэлтийн хувь 91,2 хувь байгаа боловч цус цуглуулалтын төлөвлөгөө 100 хувь биелсэн байна. Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан шинэ донорын тоо буурч байнгын донорын тоо эзлэх хувь нэмэгдсэн нь сайн үзүүлэлт юм.	100 %
----	--	------	------------------------------------	---	---	---	-------



7.	Цусны донорын “Үндэсний өдөр”-ийг тэмдэглэнэ.	1.0	Цусны донорын “Үндэсний өдөр”-ийг тэмдэглэсэн тайлан.	2020 онд Цусны донорын үндэсний өдрийг зохион байгуулж 8 донорыг алдаршуулсан.	Цусны донорын үйлсийг олон нийтэд сурталчилж, тэднийг алдаршуулсан байна.	<p>Төвийн санаачлагаар жил бүрийн 1 дүгээр сарын 3-ныг “Цусаа бэлэглэх үндэсний өдөр” болгон тэмдэглэж, ард иргэдийг цусаа бэлэглэх донорын үйлсэд уриалан цусны донорын эгнээг өргөжүүлэх, байнгын донорын тоог нэмэгдүүлэх, донорын үйлсийг сурталчлах, олон нийтэд алдаршуулах арга хэмжээг зохион байгуулдаг.</p> <p>Цусаа бэлэглэх Үндэсний өдрийн хүндэтгэлийн арга хэмжээ цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан цахим хэлбэрээр зохион байгуулсан ба JCI Монгол ТББ хамтран зохион байгуулж хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсан.</p> <p>Үндэсний өдрөөр “Хүрэл донор” цол тэмдэг-4, “Бахархал-50” тэмдгээр-1, “Бахархал-40” тэмдгээр-1, “Бахархал-30” тэмдгээр-1, “Бахархал-20” тэмдгээр-2 нийт 14 донорыг шагнаж алдаршуулан хамтран зохион байгуулагч JCI Капитал салбар байгууллагын гарын бэлэг гардууллаа.</p> <p>Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>● “Цусаа бэлэглэх өдөр”-ийг 1 сарын хугацаанд зохион байгуулж 15 салбар хамрагдаж нийт 195 донор цусаа өгч 585 хүнд амьдрал бэлэглэсэн.</li> <li>● COVID-19 цар тахлын үед хэрхэн цусаа өгөх талаар” богино хэмжээний видео контент хийж 30 000 хүнд хүргэсэн.</li> <li>● Хорооллуудын дунд оройн цагаар цусаа бэлэглэх уриалга байшингийн ханан</li> </ul>	100 %
----	---	-----	---	--	---	---	-------

						дээр гэрэлтүүлэн гаргаж сурталчилгаа хийсэн.	
--	--	--	--	--	--	---	--

8.	“Цусны донорын Дэлхийн өдөр”-ийг зохион байгуулна.	-	Цусны донорын Дэлхийн өдрийг зохион байгуулсан тайлан.	2020 онд Цусны донорын Дэлхийн өдөр цартахлын нөхцөл байдлаас шалтгаалан цахим орчинд тэмдэглэн өнгөрүүлсэн.	ДЭМБ-ын уриалгыг олон нийтэд түгээж, цусны донорын үйлсийг олон нийтэд сурталчилж, донорыг алдаршуулсан байна.	<p>Цусны донорын Дэлхийн өдөр-ийг “Цусаа бэлэглэж цохилох зүрх бүхнийг аваръя” уран дор тэмдэглэсэн.</p> <p>Бэлтгэл ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ажлын удирдамж, төсвийг батлуулан ДЭМБ-аас 7,1 сая төгрөгийн дэмжлэг авч, аймаг, Нийслэлийн ЭМБ-дад хамтран ажиллах албан бичиг, ДЭМБ-ын удирдамж орчуулгыг хүргэж чиглүүлсэн.</li> <li>• ЦДДӨ-ийн бэлтгэл ажлын төлөвлөгөө, хүндэтгэлийн арга хэмжээ Live шууд дамжуулалтын хөтөлбөрийг гаргаж, ЦДДӨ-ийг угтаж “Цусаа бэлэглэж цохилох зүрх бүхнийг аваръя” 3 сарын идэвхижүүлэлтийн аяны төлөвлөгөө батлуулж ЦСТ-д хүргүүлж, цахимаар танилцуулга хийж зөвлөгөө өгч, төрийн болон хувийн хэвшлийн эмнэлгүүд, ХХБ, Бид ББСБ, МББСБХ-нд албан тоот хүргүүлж дэмжиж хамтран ажиллахыг уриаллаа.</li> </ul> <p><b>Цусны донорын Дэлхийн өдөр-ийн Ёслол хүндэтгэлийн арга хэмжээ:</b></p> <p>Цусны донорын Дэлхийн өдөр”-ийн 18 дахь удаагийн арга хэмжээг ЭМЯ, МУЗН-тэй хамтран Цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан цахим хэлбэрээр зохион байгуулж, Эрүүл мэндийн яамны төрийн нарийн бичгийн дарга оролцон мэндчилгээ дэвшүүлж, Эрүүл мэндийн сайдын уриалгыг танилцуулсан бөгөөд ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, МУЗН-ийн ерөнхий нарийн бичгийн дарга нар цахимаар оролцож мэндчилгээ дэвшүүллээ.</p>	100 %
----	--	---	--	--	--	---	-------

					<ul style="list-style-type: none"> <li>• Цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ 35 ба түүнээс дууш удаа бэлэглэж 2021 онд хүндэт донорын болзол хангасан Нийслэлд 60, орон нутагт 53, нийт 113 Хүндэт донор төрсөн бөгөөд Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан 20 хүндэт донорын шагналыг гардууллаа.</li> <li>• “Цусны донор хамт олон”-ы шагналаар Зэвсэгт хүчний Жанжин штаб, JCI Монгол ТББ-ыг</li> <li>• <b>“Тэргүүний донор элсүүлэгч байгууллага”</b>-аар Баянзүрх дүүргийн Улаан загалмайн хороо тэргүүн байр, Сонгино хайрхан дүүргийн Улаан загалмайн хороо дэд байранд шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.</li> <li>• <b>“Шилдэг хэвлэл мэдээллийн байгууллага”</b>-аар МҮОНРТ-ийн Монголын мэдээ суваг, Төр.мн сайт, Үндэсний шуудан сониныг цусны донорын үйлсийг дэмжигч, цусны донорын үйлсийг дэмжиж ивээн тэтгэж хамтран ажилладаг ТМВВ ХХК, Нарлаг Улаабаатар ротари клуб, БИД бизнесийг дэмжигч банк бус санхүүгийн байгууллагыг шалгаруулж шагналаа.</li> <li>• ЦДДӨ-ийн цахим арга хэмжээг төвийн пейж хуудсаар шууд дамжуулж иргэд, олон нийтэд хүргэж 12 000 гаруй хандалт авсан байна. Хэвлэл мэдээллийн 16 байгууллага мэдээ бэлтгэсэн ба 88.3, 107.5 FM радио, 1 телевизэд сайн дурын авлагагүй цусны донор үйлсийн талаар ярилцлага өгч олон нийтэд мэдээлэл сурталчлагаа хийсэн.</li> </ul>	
--	--	--	--	--	--	--

					<ul style="list-style-type: none"><li>• Төвийн Донор та баатар групп, Цус сэлбэлт судлалын үндэсний төв пейж хуудсаар ёслолын арга хэмжээ болон 2021 оны шилдэгүүд, хүндэт доноруудыг алдаршууллаа.</li><li>• ДЭМБ-ын санхүүжилтээр цусны донорын үйлсийг сурталчлах сургалт сурталчилгааны 7700 материал хэвлүүлж сургалт сурталчилгаанд ашигласан.</li></ul> <p>Хавсралт. ЦДДӨ-ийн бичмэл тайлан</p>	
--	--	--	--	--	--	--

9.	Сар бүрийн 3-ны “Цусаа бэлэглэх өдөр”-ийг зохион байгуулна.	5.5	Сар бүрийн 3-ны “Цусаа бэлэглэх өдөр”-ийг 11 удаа зохион байгуулсан тайлан.	2020 онд Сар бүрийн 3-ны цусаа бэлэглэх өдрийг 11 удаа зохион байгуулж донорын эгнээг өргөжүүлсэн .	Сар бүрийн 3-ны “Цусаа бэлэглэх өдөр”-ийн үйл ажиллагааг зохион байгуулж донор алдаршуулах, сурталчлах ажлыг зохион байгуулсан байна.	<p>Сар бүрийн 3 “Цусаа бэлэглэх өдөр”-ийн 11 удаагийн арга хэмжээг цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Арга хэмжээг Сэтгэлийн 1000 үйлс ТББ, JCI капитал салбар байгууллага, Turan wold ХХК, Үнэртэй усанд дурлагсдын клуб, Бид ББСБ, ТМВВ, ЗХЖШ, МҮОНРТ, МУЗН, Монголын аялал жуучлалын холбоо, ОУ-ын Ротарагийн 3450-р дүүргийн 9, 10-р бүсийн Ротаричууд, ХХБ, МДХ зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.</li> </ul> <p>Ард, иргэдийг донорын үйлсэд уриалан цусны донорын эгнээг өргөжүүлэх, байнгын донорын эгнээг өргөжүүлэх, донорын үйлсийг сурталчлах, олон нийтэд алдаршуулахад зорилготой уг өдрөөр:</p> <p>Мөнгөн донороор -6,</p> <p>Хүрэл донороор -22,  Бахархал 10 тэмдэгээр -21,  Бахархал 20 тэмдэгээр -25,  Бахархал 30 тэмдэгээр -13,  Бахархал 40 тэмдэгээр -14,  Бахархал 50 тэмдэгээр -5  нийт 106 донорыг тодруулж шагнаж алдаршууллаа.</p> <p>Сошиал орчинд Цусаа бэлэглэсэн доноруудын талархал мэдээлэл -86, давхардсан тоогоор 92 алдаршуулах мэдээлэл байршуулж 39147 хүнд хүрсэн.</p> <p>Сэтгэлийн 1000 үйлс ТББ 18 ширхэг 242500 төгрөгийн үнэ бүхий гар утасны хэрэгслэлийн ком, дэвтэр, повербанк, машины дугаар байрлуулах хэрэгсэл, Turan</p>	100 %
----	---	-----	---	---	---	--	-------

					<p>world ХХК 8 хүний гарын бэлэг, хулдаасан хэвлэл, хүнсний бүтээгдэхүүн нийт 569000 төгрөгийн бэлгээр доноруудыг шагнаж урамшууллаа. ХХБ-ны нэрийн бэлэг 9, Монос Хүнс ХК гарын бэлэг 4 удаа , Жим интернэшнл ХХК- 4 удаа 2,274,000 төрөг бүхий өөрийн нэрийн бүтээгдэхүүнээр доноруудыг шагнаж алдаршуулсан.</p> <p>Хавсралт: Сар бүрийн 3 Цусаа бэлэглэх өдрийн тайлан.</p>	
--	--	--	--	--	--	--

10	<p>Улсын хэмжээнд ахмад настан “Хүндэт донор”, 35-аас дээш удаа цусаа бэлэглэсэн “Хүндэт донор”-ын мэдээллийн нэгдсэн санг баяжуулж, холбогдох тушаал шийдвэрийг шинэчлэх санал хүргүүлнэ.</p>	-	<p>Шинэчлэгдсэн мэдээллийн сан ЭМЯ-нд хүргүүлсэн санал</p>	<p>2020 онд 28 донорыг рашаан сувилалд амруулах, 289 ахмад настан, хүндэт донорт халамжийн тодорхойлолт тус тус олгосон.</p>	<p>Ахмад донор, хүндэт донорын мэдээллийн санд баяжилт хийгдэж, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 194, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны А/143 дугаар тушаалыг шинэчлэх санал боловсруулж ЭМЯ-нд хүргүүлсэн байна.</p>	<p>2021 оны Улсын хэмжээнд нийт 113 донор шинээр Хүндэт донорын болзол хангасан. Хүндэт донорын мэдээлийг Хүн ам хөдөлмөр нийгэм хамгаалалын яаманд хүргүүлж донорын мэдээллийн санг баяжуулж үнэмлэх тэмдэгийг гардуулсан.</p> <p>Улсын хэмжээнд Ахмад хүндэт цусны донорын 140 мянган төгрөгний түлшний үнийн хөнгөлөлтөд 754 донор хамрагдаж 105,560,000 төгрөг, орон сууцны хөнгөлөлтөд 212 донор хамрагдаж 29,680,000 төгрөг олгосон байна. УБ хотын нийт 380 донорт мөнгөн тусламж авах тодорхойлолт олгох үйлчилгээ үзүүлсэн. Мөн 103 ахмад хүндэт донор 39,300,000 төгрөгний, 35- дээш насны 14 хүндэт донор 6,100,000 төгрөгний сувилалын 100%-ийн хөнгөлөлтөнд хамрагдсан.</p> <p>Эрүүл мэндийн сайдын 2015 оны 194, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын сайдын 2013 оны А/143 дугаар тушаалыг шинэчлэх санал боловсруулж ЭМЯ-нд хүргүүлсэн. НХХЯ, НХҮТ-өөс 2022 онд цахимд шилжүүлэх тухай хариу өгсөн.</p> <p>Жилд нийт 498 донорт автобусны хөнгөлөлтэй картын үйлчилгээ үзүүлж, бүртгэл баримтжуулалт бүрэн хийгдэж 12 удаа Смарт ХХК-д хүргүүлсэн.</p>	100 %
----	--	---	--	--	--	--	-------



11	Цусны донорыг алдаршуулах, урамшуулах үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо дэмжлэгийг нэмэгдүүлнэ.	-	Шинээр шагнал, урамшуулалд хамруулсан донорын тоо	100 цусны донорыг алдаршуулж, төрийн болон төрийн бус байгууллага тай хамтран шагнаж урамшуулсан.	100-аас доошгүй цусны донорт урамшуулал олгосон байна. 5-аас доошгүй цусны донорыг төрийн болон төрийн бус байгууллагын шагналаар шагнуулсан байна.	2021 онд 4 Хүндэт донорыг төрийн шагналаар, 76 донорыг МУЗН шагналаар, 106 донорыг төвийн шагналаар, 6 донорыг Нийслэлийн шагналаар нийт 192 донорыг шагнаж алдаршуулсан. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Монгол улсын Ерөнхийлөгч 169 дугаар зарлигийн дагуу ЦДДӨ-өөр Шударга зурам медиалаар 4 Хүндэт донор шагнагдсан байна.</li> <li>• МУЗН-ийн Хүндэт донор шагналаар Улаанбаатар хотын хэмжээнд 60 донор,</li> <li>• МУЗН-ийн шагналаар хамтран ажилласан байгууллага, хүмүүнлэгийн үйлсийг дэмжигч иргэд донор 16</li> <li>• ЦССҮТ-ийн Мөнгөн донороор-6</li> <li>• Хүрэл донороор-22</li> <li>• Бахархал тэмдгээр 78</li> <li>• Гэр бүлийн донороор-6 донор гэр бүлийг Нийслэлийн гэр бүл хөгжлийн байгууллагын “Хүний төлөө” шагнал, цомоор шагнаж алдаршуулсан.</li> </ul>	100 %
----	--	---	---	---	---	---	-------

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 3. ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ЦУСНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

12	Цус, сийвэн, эс цуглуулалт, үйлдвэрлэл, борлуулалтын 2021 оны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг зохион байгуулна.	118.8	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2020 онд 26835 донороос цус цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулсан, 85500 нэгж ЦЦБ-ийг үйлдвэрлэсэн, 56560 нэгж буюу төгрөгний өөрийн орлого 1,376,017,595₮ бүтээгдэхүүн эмнэлэгт олгосон байна.байна	26500 донороос цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулж, 85500 нэгжээс багагүй ЦЦБ-ийг үйлдвэрлэсэн байна.	2021 онд 26500 донороос цусны бүрэлдэхүүн цуглуулахаар төлөвлөснөөс 27264 донор оос цус цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулж, төлөвлөгөө 102.8% биелсэн. Үүнээс суурин хэлбэрээр 18329 буюу 67.3%, явуулын хэлбэрээр 8935 буюу 32.7%-ийг эзлэж байна. Шинэ донор 9578 буюу 35.2%, байнгын донор 17686 буюу 64.8%-ийг эзлэж байна. 2021 оны 12 сарын 27 ны байдлаар 81260 нэж үйлдвэрлэсэн, төлөвгөөний биелэлт 100% байна. Суурь түвшингээс 4240 (95%) нэгжээр буурсан, шалтгаан нь Сийвэнгийн цуглуулалт буурсан, Хэвийн болон өвөрмөц иммуноглобулины үйлдвэрлэлийн түүхий эд болох 564,274 литр буюу 2726 нэгж сийвэнг бэлтгэж Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд нийлүүлсэнтэй холбоотой байна.	100%
13	Цуглуулсан цусны нэгж бүрт АВО, Резус, Келл бүлэг тодорхойлж, баталгаажуулна.	8.4	АВО бүлэг, Резус бүлэг, Келл бүлэг тодорхойлсон хувь	26300 донорт цусны бүлгийг хавсарсан аргаар, Резус бүлгийн Д эсрэгтөрөгч, Келл бүлэг тодорхойлох, баталгаажуулах шинжилгээг хийсэн.	26500 донорт 100% хавсарсан аргаар бүлэг тодорхойлж, Резус, Келл бүлэг баталгаажуулах шинжилгээг хийсэн байна.	26321 донорт 100% хавсарсан аргаар бүлэг тодорхойлж, Резус бүлэг баталгаажуулах шинжилгээг 103 донорт, Келл баталгаажуулах шинжилгээг 132 донорт тус тус хийсэн байна.	100%
14	Цуглуулсан цус, сийвэн, эсийн нэгж бүрт ХДХВ, гепатитийн В, С вирус, тэмбүүгийн	2,100.0	ELISA, PCR, CLIA аргаар нэмэлт шинжилгээг хийсэн хувь	2020 онд 26300 сорьцонд цус сэлбэлтээр дамжих халдвар	26500 донорын сорьцонд халдвар илрүүлэх шинжилгээг	26321 донороос цуглуулсан цусанд цусаар дамжих халдварын шинжилгээг фермент холбоот эсрэгбиеийн урвалын аргаар хийсэн.	100%

	халдвар илрүүлэх шинжилгээг хийнэ.			илрүүлэх шинжилгээг фермент холбох эсрэг биеийн урвалын аргаар, Эерэг гарсан 4110 нэгжид хемолюмине сценцийн аргаар, нийт 25680 сорьцонд PCR шинжилгээг хийсэн.	ELISA аргаар 100% хийж, сөрөг гарсан донорын сорьцонд PCR шинжилгээ, эерэг гарсан донорын сорьцонд CLIA аргаар нэмэлт шинжилгээг 100% хийсэн байна.	ФХЭБУ аргаар Эерэг гарсан 743 донорын сорьцонд 100% хемолюминесценцийн аргаар нэмэлт шинжилгээг хийсэн 25578 сөрөг гарсан донорын сорьцонд PCR шинжилгээг хийсэн	
15	Үйлдвэрлэсэн цус, цусан бүтээгдэхүүнд чанарын шинжилгээг хийнэ.	-	Улаан эс сийвэнгийн бүтээгдэхүүнийг шинжилгээнд хамруулсан тоо.	220 нэгж улаан эсийн, 107 нэгж сийвэнгийн, 135 нэгж эсийн бүтээгдэхүүнд чанарын, 289 нэгж цус, цусан бүтээгдэхүүнд ариун чанарын шинжилгээ хийсэн	200 нэгж улаан эсийн, 120 нэгж сийвэнгийн бүтээгдэхүүнийг чанарын шинжилгээнд, 300 нэгж цус, цусан бүтээгдэхүүнийг ариун чанарын шинжилгээнд хамруулсан байна.	-Улаан эсийн бүтээгдэхүүний 245 нэгж,  -Сийвэнгийн бүтээгдэхүүний 121 нэгж,  ·Эсийн бүтээгдэхүүний 54 нэгжийг тус тус чанарын шинжилгээнд хамруулсан. Ариун чанарын шинжилгээнд 435 нэгжийг тус тус шинжилгээнд хамруулсан байна.	100 %
16	Иммуногематологийн лавлагаа шинжилгээг хийнэ.	72.0	Лавлагаа шинжилгээний нэр, төрөл, тоо, тохирлын хувь.	7 нэр төрлийн шинжилгээг хийсэн.	Хүсэлт гаргасан шинжилгээг 100% хийж, хариуг олгосон байна.	1.Хувийн тохироо тодорхойлох шинжилгээг улсын болон хувийн эмнэлгийн хүсэлтээр нийт-713 нэгжид хийж хариуг олгосон.  2.Элэг шилжүүлэн суулгах мэс заслын үеийн хувийн тохироог УНТЭ, ХСҮТ-ийн захиалгаар нийт 1241 нэгжид дэд бүлгээр тохируулан хийж, хариуг олгож хамтран ажилласан. 3.Кумбсын шууд ба шууд бус урвал-440 4.Эсрэгбие илрүүлэх, дүйн тодорхойлох-88 5.Резусын дэд бүлэг тодорхойлох-131	100 %

						<p>6.Резус сөрөг баталгаажуулах -144</p> <p>7.Анти-Д титр тодорхойлох-649</p> <p>8. Эргэлзээтэй бүлэг тодорхойлох-28</p> <p>9.ABO бүлэг тодорхойлох-6049 хүнд хийж тус тус хариуг олгосон байна.</p>	
17	Лабораторит нэвтрүүлсэн шинэ технологиудыг нутагшуулж, хэрэглээг тогтмолжуулна.	1,682.0	Нэвтрүүлсэн шинэ технологиор хийсэн шинжилгээн ий тоо, өсөлтийн хувь	2019 онд лабораторит 5 шинэ технологийг нэвтрүүлж, нутагшуулж байна.	Шинэ технологи бүрийг нутагшуулж, хийсэн шинжилгээний тоо өмнөх оноос өссөн байна.	Лабораторит нэвтрүүлсэн 5 төрлийн тоног төхөөрөмжийг ажиллуулахад шаардлагатай урвалж оношлуурын захиалгыг төвийн төсөвт тусган ажилласан. 2020 онд Cobas s 201 хуучин PCR аппаратаар нийт шинжилгээний 80%-ийг хийж байсан бол 2021 онд шинээр нэвтрүүлсэн PCR 6800 тоног төхөөрөмжөөр нийт шинжилгээний 85%-ийг хийж урьд жилийнхээс 65%-р нэмэгдүүлсэн. Vact/Alert аппарат, Бүлэгнэлтийн CS 2400 аппаратаар 100% чанарын шинжилгээг хийсэн. HISCL 5000 аппаратаар 3500 сорьцонд шинжилгээ хийж урьд жилийнхээс 50%-р нэмэгдсэн. Иммукор аппаратаар цусны ABO, резус, келл бүлэг, резусын дэд бүлгүүд тодорхойлох шинжилгээг нийт сорьцын 25%-д хийж өмнөх жилийнхээс 10%-иар нэмэгдүүлсэн.	100 %
18	Цусны бүлэг, хувийн тохирооны үндэсний чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрийг зохион байгуулна.	-	Үндэсний чанарын гадаад үнэлгээний тайлан, гэрчилгээ	2020 онд нэг удаа зохион байгуулсан.	15 дахь удаагийн үндэсний чанарын гадаад үнэлгээг зохион байгуулан, тайланг хэлэлцүүлж, оролцогчдод үр дүн, гэрчилгээг олгосон байна.	Цусны бүлэг хувийн тохирооны үндэсний чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрийг цар тахлын нөхцөл байдлаас хамаарч жилд 1 удаа зохион төлөвлөсөн боловч 2 удаа зохион явуулсан. 2021.06.23-нд цусны бүлэг хувийн тохирооны 15 дах удаагийн чанарын гадаад хяналтын хөтөлбөрийг зохион байгуулж, 74 лабораторийг хамруулсан. 8 сарын 13-нд тайлан семинарыг зохион явуулж, оролцогч лабораториудад сертификат	100 %

						олгосон. 12 сард 16 дах хөтөлбөрийг 2021.12.21-д зохион явуулж 85 багцыг бэлтгэж 85 лабораторит тараагаад байна.	
19	Цус, цусан бүтээгдэхүүний нөөцийн тогтвортой байдлыг хадгална.	-	Сийвэнгийн болон улаан эсийн бүтээгдэхүүний нөөцийн тоо хэмжээ	Улаан эсийн бүтээгдэхүүний 850 нэгж, сийвэнгийн бүтээгдэхүүний 17394 нэгжийн нөөцтэй байна.	Сийвэн бүтээгдэхүүний нөөцийг 15000 нэгж, улаан эсийн бүтээгдэхүүний нөөцийг 900 нэгжээс багагүй байхаар бүрдүүлсэн байна.	- 2021 оны 12 сарын 22-ны байдлаар улаан эсийн бүтээгдэхүүний нөөц 1374 нэгж, сийвэнгийн бүтээгдэхүүний нөөц 17203 нэгж байна. Суурь түвшинтэй харьцуулахад улаан эсийн нөөц 524 нэгжээр нэмэгдсэн, сийвэнгийн нөөц 191 буурсан байна. Төлөвлөгөөний биелэлт 100% байна. - Хэвийн болон өвөрмөц иммуноглобулины үйлдвэрлэлийн түүхий эд болох 564,274 литр буюу 2726 нэгж сийвэнг бэлтгэж Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд нийлүүлсэн нь сийвэнгийн бүтээгдэхүүний нөөц суурь түвшингээс буурахад нөлөөлсөн.	100 %
20	Цус цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэлд нэвтрүүлсэн шинэ технологийг нутагшуулж, үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлнэ.	541.0	Шинэ технологиор үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ	2020 онд нийт 5259 нэгж шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэж, эмчилгээнд олгосон.	Шинэ технологийн цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээ өмнөх оноос буураагүй байна.	- Шинэ технологийн 10 нэр төрлийн 5259 нэгж бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхээс 5470 нэгж бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн, эмнэлгийн захиалгын дагуу 4462 нэгж шинэ бүтээгдэхүүнийг эмчилгээнд хэрэглэсэн байна. - 2021 оноос эхлэн SARS-COV-2 Эсрэгбие агуулсан эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн сийвэн бэлтгэж эхэлсэн. Нийт 303 нэгж бүтээгдэхүүн бэлтгэсэн ба халдварт өвчин судлалын үндэсний төвд хэвтэн эмчлүүлж байгаа ковид-19 хүнд өвчтөнд эмчилгээнд хэрэглэж байна.	100 %
21	ЭМБ-ыг цус, цусан бүтээгдэхүүнээр ханган нийлүүлэх гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.	-	Гэрээний тоо	2020 онд нийт 58 эмнэлэгтэй цус, цусан бүтээгдэхүүн ханган	ЭМБ-ыг цус, цусан бүтээгдэхүүнээр ханган нийлүүлэх гэрээ	ЦЦБ-ийг ханган нийлүүлэх гэрээний загварыг шинэчлэн, шинэчилсэн гэрээгээр ЦЦБ хэрэглэгч нийт 60 эмнэлэгтэй гэрээ байгуулан, дараах	100 %

				нийлүүлэх гэрээ байгуулж ажилласан.	байгуулж зөрчилгүй ажилласан байна.	хяналтыг тавьж зөрчилгүй ажиллаж байна. Үүнд: - Тусгай зөвшөөрлөл - Магадлан итгэмжлэл - Цус сэлбэлтийн зохицуулах салбар зөвлөл - Цус сэлблэтээр мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтэн - ЦЦБ-ий хадгалалт, тээвэрлэлтийн хэрэгсэлтэй байна.	
22	Гемофилийн эсрэг факторыг хүлээн авах, хуваарилах, түгээх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	1,580.0	Амбулаториор урьдчилан сэргийлэх факторыг захиалгын дагуу авсан хүний тоо, олгосон тун нэгжээр.	Гемофили А-тай 130 хүнд 3.215.500 ОУН VIII фактор, гемофили В-тэй 34 хүнд 883,500 ОУН IX факторыг олгосон.	Амбулаториор урьдчилан сэргийлэх тунгаар VIII, IX факторыг эмчийн жорын дагуу бүрэн олгосон байна.	- Жилийн эцэст 85 хүнд 8-р фактор 2,866,250 ОУН, 9-р фактор 32 хүнд 831,000 ОУН тус тус олгосон. - 2021 онд нийт Дэлхийн Гемофилийн холбооноос 5 удаа тусламжийн факторын хүлээн авсан. Тусламжийн факторын лиценз болон гаалийн хөнгөлтийн бичгийн холбогдох байгуулагт өгч шийдвэрлүүлсэн. - Тусламжийн факторын эмчилгээний зорилгоор цус бүлэгнэлтийн эмгэгтэй насан хүрэгсэдийн үе, нүдний хагалгаа, хүүхдийн гэдэсний хагалгаа, гемодиализид ордог өвчтөнд эмчилгээний тунгаар тус тус хэрэглэсэн.	100 %
23	<b>ТЭМТББ 2.5.1.1:</b> Төвийн чанарын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	-	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Чанарын хөгжлийн хөтөлбөрийн 2020 оны тайланг нэгтгэн ЭМХТ-д хүргүүлсэн.	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 2021 оны тайланг ЭМХТ-д хүргүүлсэн байна.	Төвийн чанарын хөгжлийн хөтөлбөр 2018-2023 он хүртэл 5 жилийн хугацаатай батлагдсан. Тус хөгжлийн хөтөлбөрт 4 зорилт 37 үйл ажиллагаа тусгагдсанаас 2021 онд хэрэгжүүлэх 30 үйл ажиллагаа тусгагдаж, биелэлт 98%.  Төвийн хөгжлийн хөтөлбөр, үйл ажиллагааг төвийн алба, тасгийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.  ЭМХТөвд 127 хуудас бүхий Чанарын хөгжлийн	100 %

						хөтөлбөрийн тайланг хүргүүлсэн.	
24	ХЭМАБ-ын Удирдлагын тогтолцоо-шаардлага MNS OHSAS 18001:2012 стандартаас ISO 45001:2018 стандарт руу шилжих бэлтгэл хангана.	4.0	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2018 онд MNS OHSAS 18001:2012 стандартыг хэрэгжүүлж, 2019, 2020 онд магадлах аудитад хамрагдсан.	ISO 45001:2018 стандарт нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангасан байна.	<p>- ХЭМАБ-ын баримт бичиг хянан 2021 оны хугацаа дуусч буй 15 журмыг Төвийн баримт бичиг хянах журмын дагуу сунгаж баримтжуулан, байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрээр ХЭМАБ баримт бичиг, журам, заавар, зөвлөмжийг байршуулсан.</p> <p>- ЭМС-ын тушаал, УОК-ын шийдвэрүүдийн дагуу ХСХ, Тохиолдлын журмууд шинэчлэгсэн.</p> <p>Шинээр Коронавируст халварын үеийн түр журам шинээр гаргаж үйл ажиллагаандаа нэвтрүүлэн зөвлөмжийг төвийн хаалттай групп тогтмол байршуулж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• ХЭМАБ-ын Удирдлагын тогтолцоо-шаардлага MNS OHSAS 18001:2012 стандартаас ISO 45001:2018 стандарт руу шилжих бэлтгэл ажлыг хангах ажлыг хүрээнд ХЭМАБ-ын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2021 оны 03 сарын 31-ний өдрийн Ерөнхий захирлын тушаалаар шинэчилж, 6 ажлын төлөвлөн бэлтгэл ажлыг хангасан.</li> </ul>	100 %

						<ul style="list-style-type: none"> <li>• “Олон улсын стандартын Академи”-тай гэрээ байгуулж Зөвлөлийн гишүүд болон нийт 18 эмч ажиллагсдыг ISO45001:2018 танилцуулах модуль 1, 2, 3 сургалтанд хамруулж, давхардсан тоогоор 34 хүн гэрчилгээ авсан.</li> <li>• ISO45005:2020 стандартыг танилцуулга сургалтанд онлайнаар оролцож, мэдээлэл стандартыг гарын авлагыг хүргүүлж танилцууллаа.</li> <li>• ХАБ ажилтанд зориулсан сургалтанд ХАБ ажилтан Г.Мөнхзаяа цахимаар хамрагдсан.</li> <li>• ХЭМАБ зөвлөл, Үйлдвэрлэлийн осол гэмтэл судлах бүртгэх, ХАБЭА хуулийн хэрэгжилт гэх зэрэг сэдэвт сургалтад цахимаар суралцаж судласан мэдээллийг ХЭМАБ-ийн зөвлөлийн гишүүдэд ЦССҮТ ХЭМАБ зөвлөл facebook группээр дамжуулан хүргэсэн.</li> <li>• 2021 оны байдлаар ХЭМАБ-ын зөвлөл 2 удаа дотоод хяналт үнэлгээ хийсэн. 2021.03 сард СБЦЦТ, БЗЦЦТ-үүдэд Удирдлагын тойрон үзлэг хийж, үзлэгээр илэрсэн зөрчил сайжруулах ажлын зөвлөмжийг албаны тэмдэглэлээр алба, тасаг багуудад хүргүүлсэн.</li> <li>• Шинэ ажилтны баримжаа олгох сургалтанд 2 удаа ХАБ талаар мэдээлэл өгч танилцуулсан. Шинээр ажилд орсон 9 хүн хамрагдсан.</li> <li>• 2021 оны нөхцөл байдалд уялдуулан: <ul style="list-style-type: none"> <li>-Төвийн байранд орж гарах урсгалыг тодорхойлж орох хэсэгт халдваргүйжүүлэлтийн автоматжуулсан хаалгыг 2 төв дээр байршуулсан.</li> <li>-Төвийн 1, 2-р байр, Дүнжингарав цус цуглуулах төвөөр үйлчлүүлж буй иргэд, донорууд, ажиллагсдын</li> </ul> </li> </ul>
--	--	--	--	--	--	--



						<p>биеийн халууныг тогтмол шалгаж бүртгэл хөтлөн баримтжуулан ажиллав..</p> <p>-Үйлчлүүлдэг ЭМБ-уудыг цонхоор үйлчлэх хэсэг бий болгон үйлчлүүлэгч донор нараас тусад нь байхаар зохицуулалт хийгдсэн.</p> <p>- Төвийн ажиллагсадын хөдөлмөр хамгааллын хувцасны 2021 оны нөхөн хангалтыг төвийн 65 ажилтанд 6 нэр төрлөөр хийв.</p> <p>Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны өдөр тутмын зааварчилгааг боловсруулж, ажиллагсад өглөө бүр зааварчилгаатай танилцаж, ажлаа эхлүүлж байна</p> <ul style="list-style-type: none"> <li>• Төвийн ажиллагсдын дархлааг сайжруулж эрүүл мэндийг дэмжих зорилгоор халуун аарц, чацарганаар өвлийн 3 сар, хаврын 3 сарын турш ажиллагсадыг хангасан.</li> <li>• Төвийн гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед шаардагдах нөөцийн хэрэглээг тооцон бүрдүүлэлт хийж орлого, зарлагын мэдээллийг (burtgel,mohs,mn)-д тогтмол шинэчлэн бүртгэж бэлэн байдлын ханган тайланг 7 хоног бүр эрүүл мэндийн яаманд хүргүүлж ажиллаж байна.</li> </ul> <p>Ажлын байрны нөхцөлийн үнэлгээг АШУҮИС-ийн Хөдөлмөр, орчны үнэлгээний лабораториор хийлгэхэд ноцтой зөрчил гараагүй болно.</p>	
25	Төвийн ажиллагаанд хэрэгжүүлж буй стандартад удирдлагын дүн шинжилгээ хийнэ.	-	Удирдлагын дүн шинжилгээн ий зөвлөмж, өмнөх оны шийдвэрийн хэрэгжилтийн хувь	2020 оны удирдлагын дүн шинжилгээн ий зөвлөмж, шийдвэрийг алба, тасгууд жилийн ажлын төлөвлөгөөн	Удирдлагын дүн шинжилгээний шийдвэр, зөвлөмж гарсан байна.	Жилийн хугацаанд Удирдлагын тойрон үзлэг хийх, сэтгэл ханамжийн судалгаа авах, өдөр тутмын үйл ажиллагааны үр дүн, үүрэг даалгаварын биелэлтэд дүгнэлт хийх байдлаар удирдлагын дүн шинжилгээ хийж ажилласан. Удирдлагын дүн шинжилгээний шийдвэр, зөвлөмжийг албаны	100 %

				Д тусган хэрэгжүүлсэн.		тэмдэглэлээр бүх алба, тасагт хүргүүлсэн. Хэрэгжилтийг 2022 онд хангаж ажиллан оны төгсгөлд удирдлагын дүн шинжилгээний хурлаар хэлэлцдэг уламжлалтай.	
26	Төвийн үйл ажиллагаанд дотоод болон хөндлөнгийн хяналт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангана.	-	Хяналт үнэлгээний тайлан, зөвлөмж Хөндлөнгийн үнэлгээний тайлан, зөвлөмж	Дотоод хяналтыг хуваарийн дагуу зохион байгуулж, ололт амжилтыг бүртгэн, зөвлөмжийг хүргүүлж ажилласан.	Алба тасаг бүр дотоод үйл ажиллагаандаа 2-оос доошгүй удаа хяналт үнэлгээ хийсэн байна. 1 удаа хөндлөнгийн үнэлгээ хийлгэж зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.	2021 онд хийгдэх аудитын хөтөлбөрийг боловсруулан ерөнхий захирлаар батлуулсан. Энэ онд ISO 9001:2015 стандартын магадлах аудит, ISO 15189 стандартын баталгаажуулах аудитад 2 удаа хамрагдаж, үл тохирол үлрээгүй. Нийт 14 сайжруулах санал авсан. Гадаад аудитын бэлтгэл ажлын хүрээнд дээрх чиглэлээр дотоод аудит 2 удаа зохион байгуулж, аудитын тайланг албаны тэмдэглэлээр хүргүүлж ажилласан. ЦЧАБ-ын албаны Чанарын менежер өдөр бүр алба, тасгуудаар тойрон үзлэг хийж, тусламж, үйлчилгээний чанар, халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр сайжруулах зөвлөмжийг тогтмол өгч хэвшсэн. ЦЧАБА-ны дарга нийт 7 удаа дотоод хяналтыг хийсэн байна. Дотоод хяналтын үнэлгээний явцад илэрсэн сайн ололт, дутагдалтай сайжруулах зүйлсийг тус бүр тэмдэглэж, тайлан зөвлөмжийг албаны тэмдэглэлээр хүргүүлсэн. 7 удаагийн хяналтаар бүх алба, тасгуудад 93 засч, сайжруулах зөвлөмжийг өгч хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллалаа. Мөн ХСХ-ын чиглэлээр БЗЦЦТ, СБЦЦТ, ДГЦЦТ, Явуулын цус цуглуулалтын үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтуудыг 10 удаа хийж, зөвлөмж өгч ажилласан.	100 %

27	Удирдлагын багийн тойрон үзлэг, ижил мэргэжилтний үзлэг хийнэ.	-	Тайлан, үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь.	2019 онд 2 удаа, 2020 онд 1 удаа тус тус удирдлагын багийн тойрон үзлэг, 4 удаагийн ижил мэргэжилтний үзлэг зохион байгуулсан.	Удирдлагын тойрон үзлэг, ижил мэргэжилтний үзлэгийг улирал тутам зохион байгуулсан байна.	<p>Эрүүл мэндийн байгууллагын бүх нийтийн бэлэн байдлын үед төвийн үйл ажиллагааны явц, бэлэн байдал, эрсдэлийн үнэлгээг хийх, халдварын тохиолдол нэмэгдэж байгаа үед төвийн халдвар хамгааллын дэглэм мөрдөлтөнд хяналт үнэлгээ хийж газар дээр нь холбогдох хүмүүст үүрэг чиглэл өгч, зөвлөн туслах, эмч, ажиллагсдын санал хүсэлт сонсох зорилгоор тойрон үзлэгийн 4 удаа зохион байгуулсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. 3 дугаар сарын 12-ны өдөр СБЦЦТ-ийн үйл ажиллагаанд хийж 68 асуудал илрүүлэн сайжруулах зөвлөгөө өгсөн нь 98%-ийн биелэлттэй. Гүн хөлдөөгчийг 2 давхарт гаргах асуудал цахилгааны техникийн нөхцөлөөс шалтгаалан хийгдээгүй;</li> <li>2. 9 сарын 24-нд 3 суурин төвийн үйл ажиллагаанд үнэлгээ хийж 8 сайжруулах зөвлөгөө өгсөн нь бүрэн биелэгдсэн.</li> <li>3. 10 сарын 19-нд БЗЦЦТ-ийн үйл ажиллагаанд үнэлгээ хийж 58 сайжруулах зөвлөгөө өгсөн нь 96 хувьтай. Кофе шопийн үйл ажиллагааны стандарт ажиллагааны заавар боловсруулах, НЛТ-ийн хэсэгт шилэн хаалга шинэчлэх ажил хэрэгжээгүй байна.</li> <li>4. 11 сарын 30-ны өдөр Баянзүрх цус цуглуулах төвийн үйл ажиллагаанд Ерөнхий захирлаар ахлуулсан баг удирдлагын тойрон үзлэг хийж 46 чиглэлийн үүрэг өгсөн нь 97 хувийн биелэлттэй. Үүдний хэсэгт үнэр гаргагч тавих, автомашины дугуй хадгалах хэсэг хийгдээгүй байна.</li> </ol> <p>ЭМС-ын 2019 оны А/537 дугаар тушаалын 6-р хавсралтын дагуу хамгаалах</p>	100 %
----	--	---	---	--	---	--	-------

					<p>хувцас хэрэгсэл, нэг удаагийн маскны зөв хэрэглээ, гарын эрүүл ахуй, халдваргүйжүүлэлтийн чиглэлээр төвийн нийт ажиллагсдын дунд 3 удаагийн ижил мэргэжилтний үнэлгээг зохион байгуулсан. Тасаг нэгж бүр дотроо мөрдөн ажиллах стандарт ажиллагааны заавраар ижил мэргэжилтний үнэлгээг тогтмол зохион байгуулж хэвшсэн. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"><li>• ДЗБТ- 5 удаа</li><li>• НЛТ- 4 удаа</li><li>• ҮТ- 31 удаа ижил мэргэжилтний үнэлгээ зохион байгуулсан байна.</li></ul>	
--	--	--	--	--	--	--

28	Төвийн үйл ажиллагаанд хэрэгжүүлж байгаа чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартын магадлах аудитад хамрагдана.	3.6	Магадлах аудитын тайлан, зөвлөмж	2020 онд давтан баталгаажуулалтад амжилттай хамрагдан гэрчилгээг 3 жилээр сунгасан.	Магалах аудитад амжилттай хамрагдсан байна.	Төвийн үйл ажиллагаанд хэрэгжүүлж байгаа чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартын магадлах аудитад 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хамрагдсан. Магадлах аудитын дүгнэлтээр 5 сайжруулах санал авсан. Сайжруулах саналын дагуу хэрэгжүүлэх ажлын тайланг 2022 оны 2 дугаар сарын 1-ны дотор хүргүүлнэ.	100 %
29	Цусны салбар төвүүдэд цусны аюулгүй байдлын хяналт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангана.	-	Хяналт үнэлгээнийг айлан, зөвлөмж.	2020 онд ДЭМБ-ын санхүүжилтээр 11 салбар төвд хяналт үнэлгээ хийн тайлан зөвлөмжийг хүргүүлсэн.	Цусны салбар төвийн үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангасан байна.	3-р улиралд Архангай ЦСТ, Өвөрхангай аймгийн Хархорин сумын ЦСТ, Архангай аймгийн Тариат сумын ЦСТ-ийн цусны аюулгүй байдал хангалтанд төвийн захирал, ҮТ, НЛТ-ийн тасгийн эрхлэгч нарын бүрэлдэхүүнтэй баг батлагдсан удирдамжийн дагуу явж дэмжлэгт үнэлгээг хийн үнэлгээний дүнг ЭМ-ийн байгууллагын удирдлагуудад танилцуулан зөвлөмжийг өгсөн. <b>Хавсралт. Дэмжлэгт үнэлгээний удирдамж, тайлан, зөвлөмж, илгээсэн албан бичиг</b>	100 %
30	<b>Арга хэмжээ 2.2.4.1.</b> Олон улсын чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрт хамрагдана.	6.0	Чанарын гадаад үнэлгээнд хамрагдсан шинжилгээн ий гэрчилгээ	Молекул биологи, иммунологи, бүлэгнэлт, иммуногематологийн чиглэлээр чанарын гадаад үнэлгээнд жилд 2-оос дээш удаа хамрагдсан.	Молекул биологийн хөтөлбөрт 2 удаа, бүлэгнэлт, иммунологи, иммуногематологийн гадаад үнэлгээний сорьц тээвэрлэгдэж ирсэн тухай бүрт хамрагдсан байна.	Бүлэгнэлтийн шинжилгээгээр 5-р сард WHF UK -ээс зохион явуулдаг чанарын гадаад үнэлгээний <b>survey 52-т</b> хамрагдсан.  Иммуногематологийн шинжилгээгээр 06, 08, 10-р саруудад Австралийн RCQAP-ийн Иммуногематологийн чанарын гадаад үнэлгээний Transfusion competency хөтөлбөрт 100% үр дүнтэй хамрагдсан. -Ковид-19 халдварын шалтгаанаар Австрали улсын NRL лавлагаа лабораториос зохион явуулдаг молекул биологийн болон иммунологийн чанарын гадаад үнэлгээний сорьц	100 %

						<p>тээвэрлэгдэж ирээгүйн улмаас оролцоогүй.</p> <p>-Цар тахлын нөхцөл байдлаас хамаарч ОУ-ын чанарын гадаад үнэлгээ цуцлагдаж байгаа энэ үед ЭМЯ, Sysmex корпорацитай хамтран Монгол улсад анх удаа бүлэгнэлтийн шинжилгээний чанарын гадаад үнэлгээг зохион явуулсан. 06-р сард туршилт маягаар зохион байгуулж 25 лабораторийг хамруулсан бол 12 сард анхны үнэлгээг зохион явуулж 86 лабораторийг хамруулаад байна.</p>	
31	<p><b>Арга хэмжээ 2.2.4.3.</b> Үндэсний чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрт хамрагдана.</p>	0,3	Чанарын гадаад үнэлгээнд хамрагдсан гэрчилгээ	Гематологи, биохими, бактериологийн чиглэлээр чанарын гадаад үнэлгээнд жилд 1-с дээш удаа хамрагдсан.	Бактериологи, гематологи, биохимийн шинжилгээний чиглэлээр тус бүр 1 удаа чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрт хамрагдаж гэрчилгээ авсан байна.	<p>Гематологийн шинжилгээгээр УГТЭ-ийн гадаад үнэлгээний 25, 26 дах удаагийн хөтөлбөрт амжилттай хамрагдсан. Биохимийн шинжилгээгээр УГТЭ-ийн гадаад үнэлгээний 19 дах удаагийн хөтөлбөрт 100,0% үр дүнтэй оролцсон.</p> <p>Бүлэгнэлтийн шинжилгээгээр 6-р сард Sysmex-ЦССҮТ хамтран зохион байгуулсан анхын гадаад хяналтын үнэлгээнд хамрагдаж 97,5% үр дүнтэй оролцсон.</p> <p>Нян судлалын шинжилгээгээр 11-р сард УХТЭ-ийн нян судлалын лабораторитой лаборатори хоорондын харьцуулалт хийж “Тохирсон” үр дүн гарсан.</p>	100 %
32	<p><b>ТЭМТББ 5.4.1.5:</b> Эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагааг ханган, мэргэжлийн байгууллагаар шалгалт, тохируулга, баталгаажуулалт хийлгэнэ.</p>	49.0	2021 оны тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь, Шалгалт тохируулга, баталгаажуу	Төвийн хэмжээнд нийт 381 эмнэлгийн тоног төхөөрөмж ашиглаж, төлөвлөгөөний дагуу үзлэг, үйлчилгээ урсгал засварыг	2021 оны төлөвлөгөө 100 хувь хэрэгжиж, хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, баталгаажуулалт бүрэн хийгдсэнээр үйл	<p>Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журмын дагуу төвийн хэмжээнд ашиглагдаж байгаа эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийг хэвийн найдвартай үйл ажиллагааг хангаж ажилласан. Стандартчилал хэмжил зүйн газраар хяналт шалгалт үнэлгээ хийлгэж, шалгалт тохируулга 38,</p>	100 %

			лалтын гэрчилгээ.	хийж байна. 8 тоног төхөөрөмжийн баталгаажуулалт, 60 багаж хэрэгслийн шалгалт тохируулга хийлгэсэн.	ажиллагааны тасралтгүй байдал хангагдсан байна.	баталгаажуулалт 9 нийт 47 ширхэг тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга болон баталгаажуулалтыг гэрчилгээг авсан.	
--	--	--	-------------------	---	---	--	--

**СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 4. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, СУРГАЛТ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫГ ӨРГӨЖҮҮЛЭН, ИННОВАЦИЙГ НЭВТРҮҮЛЭХ**

33	<b>ТЭМТББ 2.11.1.1:</b> Төвийн эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тодорхойлж, судалгааны ажлын төслийн санал боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлнэ.	-	Эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон хурлын протокол, Судалгааны ажлын хэрэгжилтийн хувь	Эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэл /өмнөх/, 2 судалгааны ажлын төсөл хүргүүлсэн	Төвийн эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тодорхойлсон байна. Нэмэлтээр 1-ээс доошгүй судалгааны ажлын төсөл боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэн төвийн эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тодорхойлсон. Тэргүүлэх чиглэлийн дагуу төсөл, судалгааны ажлуудыг хэрэгжүүлсэн. Үүнд:  “SARS-CoV-2 эсрэгбие агуулсан эмчилгээний сийвэн бэлтгэх” төслийг хэрэгжүүлж байна. Төслийн явцын тайланг ЭМЯ-ны ажлын хэсэгт тухай бүр хүргүүлсэн. Үүнд:  Монгол улсын Засгийн газрын “Цар тахлын эсрэг биобэлдмэл, вакцин үйлдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 144 дүгээр тогтоолоор ЦССҮТ-д коронавирусийн эсрэг сийвэнг бэлтгэж, 2021 оны III улиралд багтаан эмнэлэгийн тусламж, үйлчилгээнд нэвтрүүлэхийг үүрэг болгосоны дагуу одоогийн байдлаар нийт 227 нэгж SARS-CoV-2 эсрэгбие агуулсан эмгэгтөрүүлэгчийг идэвхигүйжүүлсэн сийвэн бэлтгэсэн. Үүнээс 30 нэгжийг өвчтөнд шууд сэлбэх боломжтой, 197 нэгжийг өвөрмөц иммуноглобулины үйлдвэрлэлд ашиглах боломжтой байна.	<b>100%</b>
----	---	---	---	--	---	---	-------------

						<p>“Эрүүл мэндийн ажилтан болон цусны донорын дунд SARS-CoV-2-ийн эсрэгбие тодорхойлох судалгаа”-г практикийн хувьд хэрэгжүүлж дууссан.</p> <p>Хүйн цусны банк байгуулах төслийн хүрээнд мэргэжилтнүүдийг гадаад улсад сургах асуудлыг ЭМХТ-ийн Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албатай 2 удаа уулзалт зохион байгуулсан. 1 хүнийг Турк улсын Ажибадем их сургуулийн эмнэлгийн сургалтад хамруулсан.</p>	
34	<p><b>ТЭМТББ 2.11.1.1:</b> Цус сэлбэлт судлалын салбарын эмч, мэргэжилтнүүдийн онол, практикийн XVIII бага хурал зохион байгуулна.</p>	-	Хэвлүүлсэн илтгэлийн хураангуй	Цус сэлбэлт судлалын салбарын эрдэм шинжилгээн ий онол, практикийн бага хурлыг зохион байгуулж, илтгэлийн хураангуйг хэвлэж илтгэгч нарт хүргэсэн.	Цус сэлбэлт судлалын салбарын эмч, мэргэжилтнүүдийн XVIII онол, практикийн бага хурал зохион байгуулагдаж, илтгэлийн хураангуйг хэвлүүлсэн байна.	<p>“Цус сэлбэлт судлалын салбарын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал” сэдэвт Эрдэм шинжилгээний XVIII бага хурлыг 9 дүгээр сарын 11-нд танхим болон цахим гэсэн хосолсон хэлбэрээр зохион байгуулж, нийт 12 илтгэлийг хэлэлцүүлсэн.</p> <p>“Төрөх эмнэлгүүдийн сүүлийн 5 жилийн цус цусан бүтээгдэхүүний хэрэглээ” илтгэл, “Төвийн ажилтнуудын дунд SARS-CoV-2 –ийн дархлаа тогтоцыг судалсан дүн” илтгэл, “Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт хийгдсэн Цагаан эсгүйжүүлсэн улаан эсийн бүтээгдэхүүний сэлбэлтийг судлах нь” илтгэлүүд эхний 3 байрыг эзэлж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан.</p> <p>Илтгэлийн хураангуй 50 ширхэгийг хэвлүүлж холбогдох мэргэжилтнүүдэд тараасан.</p>	100 %



35	<p><b>ТЭМТББ 2.11.1.1:</b> Цус сэлбэлт судлалын салбарын “Үндэсний цахим семинар”-ыг зохион байгуулна.</p>	-	Цахим семинарын хөтөлбөр, удирдамж, тайлан.	2020 онд “Үндэсний цахим семинар”-ыг зохион байгуулсан.	Үндэсний цахим семинар зохион байгуулсан байна.	<p>2021 оны 3 дугаар сарын 25-нд “Цусны аюулгүй байдлыг сайжруулах нь” сэдэвт Үндэсний цахим семинарыг зохион байгуулж, Цусны салбар төвийн 22, төвийн 20 нийт 42 эмч, мэргэжилтэнг хамруулсан. Цахим семинариар Цусны салбар төвүүдийн 2020 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, санал зөвлөмж өгсөн.</p> <p><b>Хавсралт. цахим семинарын удирдамж, тайлан</b></p>	100 %
36	Төвийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	-	Санамж бичгийн хэрэгжилтийн хувь, Гишүүнчлэл сунгасан нотолгоо	<p>Азийн цус сэлбэлтийн холбоо (AATM)-той 4 жилийн санамж бичиг байгуулсан.</p> <p>Олон улсын цус сэлбэлт судлалын нийгэмлэгийн (ISBT) гишүүнчлэл ээ сунгасан.</p>	AATM-тай санамж бичигт заасан хамтын ажиллагаа хэрэгжсэн байна. ISBT гишүүнчлэл сунгаж хамтран ажилласан тайлан.	<p>AATM-той хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд:</p> <p>AATM-тай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд хамтарсан цахим уулзалтнийг 4 удаа зохион байгуулсан. Уулзалтын товчлолыг WhatsApp группэд байршуулсан.</p> <p>AATM ын Global Journal of Transfusion Medicine сэтгүүлд “Монгол улсын Цус сэлбэлт судлалын өнөөгийн байдал” тойм өгүүлэл нийтлэгдсэн.</p> <p>6 дугаар сарын 14, 16–нд AABV чанарын гэрчилгээ, Ковид-19 халдварын үеийн ДЗБ-ын арга хэмжээ сэдвүүдийн хүрээнд мэдээлэл солилцсон.</p> <p>AATM-ын зохион байгуулж буй сургалт, вебинарыг талаарх нийт 8 мэдээллийг төвийн дотоод группэд байршуулсан.</p> <p>WhatsApp аппликейшн дах MONGOLIA CHAPTER группэд төвийн 14 ажилтныг нэмж, шуурхай мэдээллээр хангаж байна.</p>	100 %

					<p>БНХАУ-ын Шанхайн цусны төвтэй хамтын ажиллагааны гэрээний дагуу Үндэсний чанарын гадаад хяналтын програмыг хамтран хэрэгжүүлэхээр 8 дугаар сарын 18-нд ЦССҮТ, Азийн цус сэлбэлт судлалын холбоо (ААТМ), БНХАУ-ын Шанхайн цусны төвийн хамтарсан цахим уулзалт зохион байгуулсан.</p> <p>ISBT-ийн гишүүнчлэлийг 4 дэх жилдээ сунгаж, 2021 онд ЦССҮТ–д Академийн дэмжлэг авах эрх үүссэн байна.</p> <p>6 дугаар сарын 2-8 нд ISBT in Focus цахим семинарт төвийн 5 ажилтан үнэ төлбөргүй хамрагдсан.</p> <p>Видео мэдээлэл 2-ыг / ISBT ийн Harold Gunson fellowship, залуу мэргэжилтнүүдийн хөтөлбөрийн видео мэдээлэл/ төвийн дотоод группэд байршуулсан.</p> <p>ISBT education, live journal club, webinar, group registration зэрэг нийт 37 мэдээллийг төвийн дотоод группэд байршуулсан.</p> <p>ISBT-ийн Vox Sanguinis сэтгүүлийн сүүлийн үеийн 16 судалгааны ажлын холбоосыг төвийн дотоод группэд байршуулсан.</p> <p>Дэлхийн Гемофилийн холбооны 2022 оны гибрид Конгрессын бие төлөөлөгчөөр төвийн ерөнхий захирал уригдан ажилласан.</p> <p>БНТУ-ын 10<sup>th</sup> ANATOLIAN BLOOD DAYS–ийн үйл ажиллагаанд төвийн ерөнхий захирал уригдсан. Мөн улсын Истений их сургуультай харилцаа тогтоох эхний алхамуудыг хийсэн. Хүйн цусны банк байгуулах төслийн</p>
--	--	--	--	--	--

					<p>хүрээнд 1 хүнийг тус улсын улсын Ажибадем их сургуулийн эмнэлгийн сургалтад хамруулахаар тохирсон.</p> <p>Австрали улсын Sunshine Coastal University ийн судалгааны багт хамтран Multicentre study of Asian blood donors and donations судалгааг хийж байна.</p> <p>Энэхүү судалгааны төсөл нь 2020-2023 оны 3 дугаарын 26 хүртэлх үргэлжилнэ.</p> <p>3-р сард Судалгааны багийн зүүм уулзалтад оролцож, санал солилцсон. ЦССҮТ-өөс илгээсэн датад тайлбар өгч, зөвлөмж авсан.</p> <p>Multicentre study of Asian blood donors and donations судалгааны ажил ISBT-д анхны судалгааны хураангуйг илгээсэн.</p>		
37	<p><b>ТЭМТББ 2.11.1.1:</b> Цусны аюулгүй байдал, цус цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээний багц цагийн сургалт зохион байгуулна.</p>	-	<p>Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан эмч мэргэжилтний тоо</p>	<p>2020 онд “Цусны аюулгүй байдал” сургалтыг 2 удаа зохион байгуулсан. Цусны бүлэг, хувийн тохироо тодорхойлох багц цагийн сургалтад 18эмнэлгийн 46 эмч, мэргэжилтнийг хамруулсан.</p>	<p>Цусны аюулгүй байдал, цус цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээ, цусны бүлэг, хувийн тохироо тодорхойлох багц цагийн сургалтыг тус тус зохион байгуулсан байна.</p>	<p>Цусны аюулгүй байдал, цус цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээ сургалтыг цар тахлын нөхцөл байдлын улмаас 2 дугаар улирлаас эхлэн цахим болон танхим хосолсон хэлбэрээр нийт 6 удаа зохион байгуулж, УБ хот, орон нутгийн 6 эмнэлгийн байгууллагын нийт 152 эмч мэргэжилтнийг хамруулсан. Үүнд:</p> <p>4-р сард Гэмтэл Согог судлал үндэсний төв, 60 эмч, мэргэжилтэн</p> <p>6-р сард, “Бриллиант” хувийн эмнэлэг, 23 эмч мэргэжилтэн,</p> <p>9 сард “Нийслэлийн Хүрээ амаржих газар” төрөх эмнэлэг, 21 эмч, мэргэжилтэн,</p>	100 %

						<p>9-р сард УХТЭ, Гастроэнтрологийн тасаг, 10 эмч мэргэжилтэн,</p> <p>9-р сард Өвөрхангай аймгийн Нэгдсэн эмнэлэг, 23 эмч, мэргэжилтэн,</p> <p>9-р сард Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн эх барих эмэгтэйчүүдийн 15 эмч, мэргэжилтэн, цахим хэлбэрээр тус тус зохион байгуулсан.</p>	
38	<p><b>ТЭМТББ 2.11.1.1:</b> Эмнэлзүйн цус сэлбэлт судлалын их эмчийн мэргэшүүлэх, цус, цусан бүтээгдэхүүний технологич сувилагчийн мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулна.</p>	-	Суралцагчдын элсэлт, төгсөлтийн тушаал	2020 онд Эмнэлзүйн цус сэлбэлт судлалын их эмчийн мэргэшүүлэх сургалтыг 7 эмч цус, цусан бүтээгдэхүүний технологич сувилагчийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг 9 сувилагч төгссөн.	Эмнэлзүйн цус сэлбэлт судлалын их эмч мэргэшүүлэх, цус, цусан бүтээгдэхүүний технологич сувилагчийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан байна.	<p>Эмнэл зүйн цус сэлбэлт судлалын их эмчийн төрөлжсөн мэргэшлээр 4 эмч Налайх НЭ, Орхон НЭ, Говь-Сүмбэр НЭ, Люкс Мед эмнэлгээс суралцаж, 100% амжилттай төгссөн. ЭМС –ийн А/708 дугаар тушаалаар төгсөж, гэрчилгээ гардуулан өгсөн.</p> <p>ЭМС-ийн А/653 дугаар тушаалаар 2021 оны 10 дугаар сарын 01-ээс тус сургалтад нийт 4 эмч элсэн суралцаж байна. Үүнд: ЦССҮТ-өөс 3, Булган АНЭ 1 эмч эмч элсэн суралцаж байна.</p> <p>Цус цусан бүтээгдэхүүний технологич сувилагчийн мэргэжил дээшлүүлэх сургалтад Архангай АНЭ, Говь-Сүмбэр АНЭ, ЦССҮТ – өөс нийт 3 сувилагч суралцаж, ЭМХТ-ийн ерөнхий захирлын А/44 дүгээр тушаалаар төгссөж, гэрчилгээ олгосон.</p> <p>ЭМС–ийн А/130 дугаар тушаалаар 2021 оны 10 дугаар 01-ээс технологич сувилагчийн мэргэжил дээшлүүлэх сургалтад ЦССҮТ-өөс 2, Завхан Тосонцэнгэл сумын НЭ 1, Дорнод БОЭТ-1, Нийслэлийн Амгалан амаржих газар-1, Монгол-Японы эмнэлгээс 1</p>	100 %

					<p>сувилагч нийт 6 сувилагч элсэн суралцаж байна.</p> <p>Архангай, Сэлэнгэ, Дорноговь аймгуудаас ирсэн 4 лаборантад лабораторийн дагалдан сургалт хийсэн.</p>	
39	UPTODATE цахим платформыг ашиглана.	-	Ашигласан эмчийн тоо, сургалтын сертификатын оноо	-	<p>Олон улсын эмнэлзүйн цахим платформ ашиглаж сургалт зохион байгуулсан байна.</p> <p>Мэдээллийн технологийн инженер 2-р сард зохион байгуулагдсан UP TO DATE програмын баримжаа олгох сургалтад хамрагдаж, байгууллагын нийт эмч нарт мэдээлж, 7 эмчийн бүртгэлийг хийсэн. Байгууллагын сүлжээний хаягийг бүртгүүлсэн. Байгууллагын сүлжээнээс UP TO DATE программыг ашиглах эрх нээгдсэн.</p> <p>2021 онд хэвлэгдэн гарсан сүүлийн үеийн цус цусан бүтээгдэхүүн, сийвэнгийн эмчилгээ, хүйн цусны банкны талаарх мэдээг олж аван, ЦССҮТ-ийн дотоод сайтад танилцуулан ажиллаж байгаа.</p> <p>Үүнд: UPTODATE хуудсанд эмч, сувилагч нарыг яаж бүртгүүлэх, бүртгүүлсэнээр ямар ач холбогдолтой талаар мэдээлэл ЦССҮТ –ийн хуудсанд 9 сарын 24 нд тависан, хандалтын тоо- 58 байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• 2021 онд хэвлэгдэн гарсан сүүлийн үеийн цус цусан бүтээгдэхүүн, сийвэнгийн эмчилгээ, хүйн цусны банкны талаарх нийт 4 мэдээг авсан.</li> <li>• 2021 оны 9 сарын 30 нд ЦССҮТ-ийн дотоод сайтад танилцуулсан, хандалтын тоо 58 байна.</li> </ul>	100 %

40	Цусны донорын “Донор аппликейшн”-ийг хөгжүүлнэ.	1.0	Хөгжүүлэлт хийсэн баримтжуулалт	Гар утасны андройд үйлдлийн системд ажилладаг.	Апплейшн хөгжүүлэлт хийгдсэн байна. Иргэд, цусны донор гар утасны үйлдлийн системээс хамааралгүй Донор апплейшныг ашигладаг болсон байна. Апп Store хөгжүүлэлт хийж ашигладаг болно.	МУЗН-тэй хамтран “Донор апплейшн”-ийг хөгжүүлэх зорилгоор шинэчлэн гар утасны үйлдлийн системээс хамааралгүй ажиллах, донор урьдчилан Донорын эрүүл мэндийн карт, сэтгэл ханамжийн судалгаа бөглөх зэрэг нэмэлт үйлдлүүдийг шинэчилэн тест хийж ашиглаж эхлээд байна.  “MGL Blood Donor App” гэж нэрийг өөрчилсөн, Төвийн цахим хуудас, “MGL Blood Donor App” апплейшны үйл ажиллагааны журмыг батлуулан мөрдөн ажиллаж байна.	100 %
41	Донорын бүртгэлд “Хур” төрийн мэдээлэл солилцооны системийг нэвтрүүлж, хөгжүүлнэ.	3.0	“Хур” системтэй холбогдсон донорын цахим бүртгэл	Улсын Үндэсний Дата Төвтэй “Төрийн мэдээллийн солилцооны системийг ашиглах” гэрээ хийсэн.	Донорын цахим бүртгэлийг “Хур” системтэй холбосон байна.	Үндэсний дата төвөөс Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системийн ашиглах сертификатыг /заавар, код/ авсан ба Үндсэн үйл ажиллагааны програмд холбох ажлыг Битсофт ХХК-аар гэрээгээр гүйцэтгүүлж байна. Мөн Монгол Улсын Их Хуралын Инновац, цахим бодлогын хорооны 2021 оны 01 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төвийн үндсэн үйл ажиллагааны програмаас Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-д Цус сэлбэлт судлалын салбараар үйлчлүүлсэн цусны донор үйлчлүүлэгчдийн бүлгийг мэдээллийг харуулахад бэлэн болгоод байна.	100 %

42	Мэдээллийн технологид суурилсан харилцаа холбооны үйлчилгээг тогтмолжуулна.	0,5	Call pro үйлчилгээний тайлан, мэдээ Chatbot үйлчилгээг ашигласан тайлан	70112857 дугаараар Call pro үйлчилгээ нэвтэрсэн. Chatbot үйлчилгээ ашиглах эрх дууссан.	Call pro үйлчилгээ ашиглан үйлчлүүлэгчийг стандарт мэдээллээр цаг алдалгүй тогтмол хангаж, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж дээшилсэн байна.	<p>Call Pro үйлчилгээний дашбаорд эрхийг сэргээн авсан. Долоо хоног бүрийн эрсдлийн харилцаа холбооны тайланд мэдээг өгч байна.</p> <p>2021 оны байдлаар нийт дуудлага давхардсан тоогоор 6851 байсанаас хандалт авсан 4215, хандалт хийгдээгүй 2582 байна. Үүнээс ажиллах цагийн хуваарь болон салбаруудын мэдээлэл авсан 15%, цус өгөх талаар 19%, цусны бүлэг тодорхойлох талаар 6%, цусаа өгсөний дараах мэдээлэл 1%, төвийн ажилтантай холбогдох 49%, дахин сонсох нь 10% тус тус үзүүлэлттэй.</p> <p>Chatbot үйлчилгээ 2020 онд үйл ажиллагаанд орсон ба 2020 оны 11 дүгээр сараас ажиллагаагүй болсон асуудлыг судалсан ба олон улсын manychat LLC сар бүрийн үйлчилгээний хөлс төлөх шаардлагатай болсон байсан.</p> <p>1-р сараас 250 хэрэглэгч хүртэл үнэгүй ашиглах боломжтой Many chat bot үйлчилгээнд bot угсралтыг хийн ЦССҮТ-ийн пейжед холбон ашиглаж эхэлсэн.</p> <p>Хэрэглэгчийн тоо 1000 хүрснээр цаашид төлбөргүйгээр ашиглах боломжтой болсон. Компьюдаас үнийн санал авч, судлан чатбот мн ХХК компанитай гэрээ байгуулсан.</p>	10
43	Донорын эрүүл мэндийн картыг цахимжуулна.	4.0	Цахим эрүүл мэндийн картад шилжсэн донорын тоо	-	Цахим эрүүл мэндийн картыг нэвтрүүлж, хүлээгдлийг бууруулж сэтгэл	МУЗН-тэй хамтран хэрэгжүүлж байгаа “MGL Blood Donor App” -ийг хөгжүүлэх ажлын хүрээнд донорын эрүүл мэндийн картыг “MGL Blood Donor App”-д оруулсан. Донор урьдчилан ДЭМК бөглөж үйлчлүүлэх	100 %

					ханамжийг нэмэгдүүлсэн байна.	нөхцөлийг бүрдүүлсэн ба "MGL Blood Donor App"-ийн хамт тестийн ажил хийгдэж байна.	
44	<b>ТЭМТББ 5.3.1.2</b> Төвийн хөрөнгийн удирдлагын цахим мэдээллийн санг баяжуулна.		Хөрөнгийн удирдлагын цахим мэдээллийн сан Хүйтэн хэлхээний мэдээллийн бааз	Засвар үйлчилгээ, удирдлага хяналтын системийн баазыг шинэчлэх, хүйтэн хэлхээ температур хяналтын систем засварлах шаардлагат ай.	Засвар үйлчилгээ, удирдлага хяналтын системийн мэдээллийн баазыг шинэчилсэн байна. Хүйтэн хэлхээний мэдээллийн бааз үүссэн байна.	Өмч хамгаалах зөвлөл засвар үйлчилгээ, удирдлага хяналтын системийн мэдээллийн баазыг хөрөнгө бүртгэлд тусгах тухай Ерөнхий захирлын 4 сарын 9-ний А/11 тушаалын дагуу 14 нэрийн 4,935,000 төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл, 6 сарын 30-ны А/30 дугаар тушаалын дагуу 13 нэрийн 32,417,800 төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэж баяжуулсан.  ТӨБЗГ-ын 5 дугаар сарын 20-ны өдрийн 178 дугаар тогтоолын дагуу 57 нэрийн 279,008,364 төгрөгийн үндсэн хөрөнгө /тавилга, тоног төхөөрмж/ -ийг Засвар үйлчилгээ, удирдлага хяналтын системийн мэдээллийн баазаас хасалт хийж шинэчилсэн.  Хүйтэн хэлхээ хяналтын системд тохиргоо хийж хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжүүдийг холбох ажил хийгдсэн, програмыг хөгжүүлэхээр ажиллаж байна.	100 %
45	Төвийн интернэт, болон хяналтын камерыг сайжруулан хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	7.5	Шинээр суурилуулсан хяналтын камерын тоо, Интернетийн хурд	Төвийн интернетийн хурд БЗД 6mpbs СБД 3mpbs байна. СБ ЦЦТ-д аналог болон IP 8 камер, БЗ ЦЦТ аналог 10, IP 31 камер тус тус ашиглаж байна.	Төвийн интернетийн хурдыг БЗД 10 mpbs, СБД 5 mpbs болгосон байна. 34 ширхэг хяналтын камер, 1 ширхэг хяналтын камерын төхөөрөмж, 6 ширхэг сүлжээний төхөөрөмжөөр	Байгууллагын интернетийг сайжруулах ажлыг зохион байгуулж ажилласан. БЗЦЦТ-ийн интернетийн хурдыг 6 мегабайтаас 10 мегабайт, СБЦЦТ-д 3 мегабайтаас 6 мегабайт болгон нэмэгдүүлснээр БЗЦЦТ-ийн интернетийн хурд 40%, СБЦЦТ-ийн интернетийн хурд 50%-иар тус тус нэмэгдсэн.  Төвийн 3 байрны хэмжээнд 68 хяналтын камер суурилуулсаны 13 нь гадаад орчинд, 55 нь дотоод орчинд	100 %



					<p>нэмэгдүүлж сайжруулсан байна.</p>	<p>байршуулж, хяналтын дэлгэцийн тохиргоонд байнга хянах шаардлагатай 16 камерын холбон камерын хяналтын системийг өргөжүүллээ. БЗД-ийн хяналтын камерын бичигч төхөөрөмжийг үзүүлэлт өндөртэй бичигчээр сайжруулж тохиргоог хийсэн.</p> <p>Төвийн камерын хяналтын системийн ашиглалтын журмыг боловсруулн төвийн захирлаар батлуулсан мөрдөж ажиллаж байна.</p>
--	--	--	--	--	--------------------------------------	---

**СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 5. ХҮНИЙ НӨӨЦИЙН ЁС ЗҮЙ, УР ЧАДВАР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ**

46	Төвийн хүний нөөцийн хөгжлийг хангах 2021-2025 оны хөтөлбөр боловсруулна.	-	Батлагдсан хөтөлбөр, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилийн хувь	Хүний нөөцийн хөгжлийг хангах дунд хугацааны хөтөлбөр /2018-2020/ хэрэгжсэн.	2021-2025 оны хөтөлбөрийг шинээр батлан 2021 оны төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	<p>Хүний нөөцийн хөгжлийг хангах 2018-2021 оны хөтөлбөрийн хэрэгжилт 90 хувьтай хангагдсан. Төрийн албаны тухай хуулийн дагуу албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулж, нийт ажилтанд танилцуулга хийгдсэн.</p> <p>Төвийн хүний нөөцийн хөгжлийг хангах 2021-2025 оны хөтөлбөр, Хүний нөөцийн төлөвлөлт 2021-2031 он баримт бичиг боловсруулан батлуулсан. 2021 онд Ажилтны идэвхи, санаачлагыг нэмэгдүүлэх, алдаршуулах зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 1 эмчид Монгол улсын цол 9 ажилтанд одон, медаль, Засгийн газрын шагналаар 8, ЭМЯ-ны шагналаар 17 ажилтныг шагнуулсан. Эрүүл мэндийн салбарын 100 жилийн ойг тохиолдуулан 6 ажилтны төрийн дээд одон, медалиар шагнуулахаар тодорхойлсон.</p> <p>Хүний нөөцийн нөхөн хангалтыг жилийн турш 95-100 хувьтай бүрдүүлж ажилласан. Оны эхнээс 4 ажилтанд жирэмсэний болон амаржсаны амралт олгож 2 ажилтныг өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор шилжүүлж, 9 ажилтныг өөрийн хүсэлтээр чөлөөлөв. Zangia.mn сайт, байгууллагын цахим хуудсаар сул ажлын байрны зар байрлуулж, 13 ажилтныг туршилтын хугацаагаар томилон, хүүхэд асрах чөлөөтэй байсан 4 ажилтныг ажилд нь томилсон. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэлт, эмнэлэгийн мэргэжилтний хариуцлага сэдэвт сургалт, мэдээлэл 3 удаа /төгсөлтийн дараах</p>	100 %
----	---	---	---	--	--	--	-------

					<p>сургалт болон баримжаа олгох сургалтад/ хийсэн.</p> <p>Хавсралт. Төвийн хүний нөөцийн хөгжлийг хангах 2021-2025 оны хөтөлбөр, Хүний нөөцийн төлөвлөлт 2021-2031 он</p>	
--	--	--	--	--	---	--

47	Төвийн эмч, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулна.	-	Мэргэшүүлэх болон, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний тоо	-	Шинэ болон хүлээгдэж байгаа эмч, мэргэжилтнүүдийг сургалтад хамруулсан байна.	<p>2021 оны Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтад:</p> <p>Эмнэлзүйн цус сэлбэлт судлал их эмчийн төрөлжсөн мэргэшлийн сургалтад төвийн 3 их эмч, Цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологич сувилагчийн мэргэжил дээшлүүлэх сургалтад 2 сувилагч хамрагдан суралцаж байна.</p> <p>Үйлчлэгч ариутгагчийн сургалтад 1 үйлчилгээний ажилтан, Этүгэн Их сургуульд туслах сувилагчийн мэргэжлээр 2 үйлчилгээний ажилтан, Дизайны мэргэжлээр 1 лаборант суралцаж байна.</p> <p>Мэдээллийн технологийн инженер UP TO DATE програмын баримжаа олгох сургалтад хамрагдаж, байгууллагын нийт эмч нарт мэдээлж, 7 эмчийн бүртгэлийг хийсэн.</p> <p>Төрөлжсөн мэргэшлийн Трансфусиологийн курсэд суралцагч нарт төлбөрийн хөнгөлөлт үзүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2021 онд 5 ажилтан хамрагдсан.</p>	100 %
----	--	---	---	---	---	--	-------

48	Төвийн эмч, ажиллагсдын ёс зүй харилцаа хандлага, хариуцлагыг сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.	-	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Жил бүр төлөвлөгөө гарган ажиллаж хэрэгжилтийг Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороонд тайлагнадаг.	Төлөвлөсөн ажил бүрэн хэрэгжиж, ажиллагсдын ёс зүй харилцаа хандлагатай холбоотой гомдол бүртгэгдээгүй байна.	<p>Тайлангийн хугацаанд эмнэлгийн мэргэжилтний ёс зүй салбар хороо нийт 3 удаа хуралдаж, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны 2020 оны тайлан, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцэн батлуулсан бөгөөд 100 хувь биелсэн.</p> <p>Түүнчлэн мэргэшлийн зэргийн шалгалтанд оролцох сувилагч нарын болон шинжээчээр ажиллах эмчийн талаарх асуудлаар хуралдаж, Ёс зүйн зөрчилгүй тодорхойлолтыг олгохоор шийдвэрлэв.</p> <p>Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд сургалтыг дараах сэдвүүдээр зохион байгуулсан:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулагдсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй” багц цагийн богино хугацааны цахим сургалтанд хамрагдаж, биелэлтийг хугацаанд хүргүүлсэн.</li> <li>2. “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, төлөвшил, хариуцлага” Эрдэм шинжилгээ, онол практикийн улсын анхдугаар цахим хуралд төвийн ЁЗСХ бүрэлдэхүүн болон эмч, мэргэжилтнүүдийг оролцуулсан.</li> <li>3. ЭМЯ, ЭМХТ-өөс зохион “Амжилтанд хөтлөх ур чадвар” сэдэвт цахим сургалтанд төвийн эмч, мэргэжилтнүүд хамрагдаж, харилцаан зөөлөн</li> </ol>	100 %
----	---	---	---	---	---	--	-------

					<p>ур чадварыг хөгжүүлэх талаар мэдээлэл авсан.</p> <p>4. “Ажлын байран дээрх стресс менежмент” сэдэвт сургалтыг танхим болон цахимаар зохион байгуулсан.</p> <p>Төвийн шинэ ажилтнуудад Ёс зүй харилцаа хандлага, эрүүл мэндийн ажилтны хариуцлага сэдвээр 3 удаа хичээл орсон.</p> <p>2021 онд Эмнэлгийн мэрэгжилтний ёс зүйн салбар хороонд үйлчлүүлэгчээс эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд гаргасан ёс зүйн өргөдөл, гомдол ирээгүй.</p> <p>Төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнаас 2 удаа асуумж авсан:</p> <p>- Эхний хагас жилд 42 ажилтнаас асуумж авч дүгнэсэн. Ерөнхий сэтгэл ханамж сайн гэж 78,6% нь, дунд 21,4% гэж үнэлсэн байна.</p> <p>Сүүлийн хагас жилд сэтгэл ханамжийн судалгааг цахим хэлбэрээр (<a href="https://docs.google.com/forms/d/1wCiXK7T1L-87bxGNCGbR19vlaky6XPSIRObJ1gMHjp8/edit?fbclid=IwAR06vhS4phG--uCewPvJilmSvdGWI4D7MV_IzdUDmMmDcMhQleL2AhJVpec#responses">https://docs.google.com/forms/d/1wCiXK7T1L-87bxGNCGbR19vlaky6XPSIRObJ1gMHjp8/edit?fbclid=IwAR06vhS4phG--uCewPvJilmSvdGWI4D7MV_IzdUDmMmDcMhQleL2AhJVpec#responses</a>) 5 бүлэг асуумжаар нийт 49 ажилтнаас авч дүгнэхэд Ерөнхий сэтгэл ханамж сайн гэж 93,9% нь, дунд 6.1% гэж үнэлсэн байна.</p> <p><b>Хавсралт. Төлөвлөгөө, тайлан</b></p>	
--	--	--	--	--	--	--

49	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгаалал үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	5.4	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	2020 онд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг НЭМҮХ, ЭМЯ-д хүргүүлсэн.	2021 оны төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	<p>Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо-Шаардлага MNS OHSAS 18001:2012 стандартыг төвийн үйл ажиллагаанд 2016 оноос хэрэгжүүлэн 2018 онд Стандартчлал хэмжилзүйн үндэсний газраар баталгаажуулалт хийлгэн 3 жилийн хугацаатай авсан.</p> <p>- ЦЧАБ-ын албанаас Төвийн Чанар болон ХЭМАБ-ын гарын авлагыг нэгтгэн стандартын 1-10 бүлгийн заалтын дагуу боловсруулж төвийн УЗ-ын хурлаар хэлэлцүүлж батлуулах, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо MNS ISO 45001:2018 стандарт руу шилжих төлөвлөлт гарган 90% хэрэгжилттэй бэлтгэлийг ханган ажиллаж байна.</p> <p>2021 оны 06 дүгээр сарын 23-ны А/32 тоот тушаалаар НЛТ-ийн эрхлэгч М.Цэрэндэжид – 40%/18 хоногоор/, 2021 оны 07 дүгээр сарын 23-ны А/39 тоот тушаалаар НЛТ-ийн эрхлэгч М.Цэрэндэжид–40%, технологич сувилагч Н.Энхтуул – 40% /10хоногоор/ тус тус нэмэгдэл олгосон.</p> <p>Ковид-19 цар тахалтай холбогдуулан ажилтнуудын эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх зорилгоор хувийн хамгаалах хэрэгслээр хангах, витаминжуулах, шинжилгээнд хамруулах ажлыг хийж байна.</p> <p>Нийт ажилтнуудад өдөр бүр халуун чацаргана, аарцаар үйлчлэхэд 1.182.500 төгрөг, 1 сарын хэрэглээний витамин олгоход 937,000 төгрөг тус тус зарцуулсан.</p> <p>Мөн СҮА-ны үйлчлэгч В.Ганцэцэг, Д.Батхүү нэр гавьяаны амралтаа эдлэх болсон тул нэг удаагийн тэтгэмж олгуулсан.</p>	100 %
----	--	-----	---	--	--	--	-------

					<p>2021 онд ахмад ажилтан С.Намсрайжав, ажилтан Б.Мөнгөнтуул, Б.Есүүн, Ц.Өлзийхишигт тус тус хамтын гэрээний 7.3.5 дахь заалтыг дагуу 300,000₮, Д.Дулмаад 500.000₮, ҮЭХ-оос Д.Сарантуяад 150.000₮ , жирэмсэний амралт авсан А.Заяабилэг, С.Ганчимэг, Х.Жавзандулам нарт 1 сар өдрийн хоол идэхэд зориулан 150.000₮ тус бүр олгосон. МУЗН-д хүсэлт тавьж амьдралын нөхцөл хүндрэлтэй 20 ажилтанд 4.800.000₮-ийн буцалтгүй тусламж олгуулсан.</p> <p>Ковид-19 халдвараас сэргийлэхтэй холбоотой Засгийн газрын тогтоол, Эрүүл мэндийн сайдын тушаал, Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу Цалинтай чөлөөг 27 ажилтанд олгосон. Төлөвлөгөөний хэрэгжилт бүрэн хангагдсан.</p>	
--	--	--	--	--	--	--



**СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 6. ТӨВИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ, ХӨГЖҮҮЛЭХ**

50	Төвийн стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулна.	-	Батлагдсан стратеги төлөвлөгөө	Төвийн 2017-2020 оны хөгжлийн хөтөлбөр хэрэгжиж үнэлгээ хийсэн.	Төвийн 2021-2025 оны стратеги төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлж эхэлсэн байна.	<ul style="list-style-type: none"> <li>Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг мандатын шинжилгээ, алсын хараа, эрхэм зорилгоо тодорхойлсон. Төлөвлөгөөний ерөнхий төслийг боловсруулсан.</li> <li>ЭМЯ, ЭМХТ-ийн хамтран зохион байгуулсан Стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй сэдэвт 3 өдрийн цахим сургалтад ажлын хэсгийн гишүүдийн хамруулсан.</li> <li>Удирдлагын академиас Зөвлөх үйлчилгээ авч Стратеги төлөвлөгөө шинэчлэн боловсрууж батлуулахаар ажиллаж байна.</li> </ul>	90%
51	Маркетингийн дунд хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	-	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	2020 оны төлөвлөгөө 87%-тай хэрэгжсэн.	Маркетингийн хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилтийг хангасан байна. Дунд хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлсэн байна.	Төвийн “Маркетингийн хөтөлбөр 2017-2021”-ийн хэрэгжилтийг хангах 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан. 2021 оын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 97.4% байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээг хийж байна.  <b>Хавсралт. Маркетингийн хөтөлбөрийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан</b>	100%
52	ДЭМБ-д Цус сэлбэлт судлалын салбарын 2019 оны тайланг хүргүүлнэ.	-	ДЭМБ-д хүргүүлсэн тайлан.	ДЭМБ-д Цус сэлбэлт судлалын салбарын 2018 оны тайланг хүргүүлсэн.	ДЭМБ-д Цус сэлбэлт судлалын салбарын 2019 оны тайланг хугацаанд нь хүргүүлсэн байна.	Цус сэлбэлт судлалын салбарын 2019 оны тайлангаас ДЭМБ-д мэдээллэдэг үзүүлэлтийг 2018 оны ирүүлсэн хүснэгтээр нэгтгэн тайланг илгээсэн.	100%

53	Цус сэлбэлт судлалын салбарын 2020 оны тайлан мэдээллийг нэгтгэн, ЭМХТ-д хүргүүлж, дүн шинжилгээ хийнэ.	-	Цус сэлбэлт судлалын салбарын 2020 оны мэдээ, тайлан	Жил бүр Цус сэлбэлт судлалын салбарын тайлан мэдээллийг Улсын хэмжээнд нэгтгэж ЭМХТ-д хүргүүлдэг.	Цус сэлбэлт судлалын салбарын 2020 оны тайлан мэдээллийг ЭМХТ-д хугацаанд нь хүргүүлж, эрүүл мэндийн статистик мэдээнд оруулсан байна.	<p>Төвийн 2020 оны жилийн үйл ажиллагааны тайлан болон Цус сэлбэлт судлалын салбарын 2020 оны жилийн үйл ажиллагааны нэгтгэсэн тайланг бэлтгэж ЭМХТ-д тайлангийн хугацаанд цахимаар хүргүүлсэн. ЭМХТ-ийн 2021 оны 794 дугаар тушаалаар тайланг тушаалт 92 (А) дүнтэй үнэлэгдсэн.</p> <p>ЭМХТ-өөс эрхлэн гаргадаг Эрүүл мэндийн үзүүлэлт 2020 номны 9-р бүлэгт Цус сэлбэлт судлалын салбарын 2016-2020 оны 5 жилийн статистик үзүүлэлт, 2020 оны онцлох үйл ажиллалааг нэгтгэн хэвлүүлж олны хүртээл болгосон.</p> <p>Цус сэлбэлт судлалын салбарын 2010-2020 оны статистик үзүүлэлтийг нэгтгэн дүн шинжилгээ хийж удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан.</p>	100 %
54	<b>ТЭМТББ 2.5.2.4</b> Байгууллагын үйлчилгээ, соёлыг хөгжүүлнэ.	-	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	2020 оны төлөвлөсөн арга хэмжээ 83%-тай хэрэгжсэн байна.	Ажилтнуудын болон үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлсэн байна.	<p>Сэтгэлд нийцсэн үйлчилгээний баг 2021 үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан. Жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 85,1%-тай байна.</p> <p>Хэрэгжүүлсэн арга хэмжээ:</p> <p>1. Ажилчдын дунд ёс зүй, харилцаа хандлагын сургалтыг тогтмол зохион байгуулах, эрх бүхий байгууллагаас зохион байгуулсан сургалтанд хамруулах ажлыг хэрэгжүүлсэн.</p> <p>Үүнд: “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй” цахим сургалт, “Бодол санааны хүч ба бясалгал”, “Амжилтанд хөтлөх чадварууд”, “Аз жаргал ба стресс”, “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын үндсэн 6 зарчим”, “Эрүүл зөв зохистой</p>	100 %

					<p>хооллолт” сургалтуудад давхардсан тоогоор нийт 239 ажилтан хамрагдсан.</p> <p>1. Сэтгэл ханамжийн судалгаа авч үр дүнг нэгтгэн үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн. Үүнд:</p> <p>а. Донор үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгааг авч нэгтгэн судалгааны үр дүнг Донор зохион байгуулалтын тасгийн хуралд танилцуулсан.</p> <p>б. Үйлчлүүлэгч 20 эмнэлэг сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсанаас 14 санал (танай хамт олонд баярлалаа, хамтран ажиллахад таатай байдаг шүү, одоо бүх эмнэлгүүд цахимд шилжиж байгаатай холбоотой зарим нэг асуудлыг эрүүл мэндийн яамтай хамтран шийдвэрлэж өгвөл сайн байна), 3 талархал, саналгүй гэсэн 3 эмнэлэг байна.</p> <p>в. Нэгдсэн лабораторийн тасгаас 100 үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авч судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэхэд 99-100 хувийн сэтгэл ханамжтай байна.</p> <p>Цус,цусан бүтээгдэхүүн олгох жижүүрийн сувилагч утсаар болон биеэр донорын тухай мэдээлэл, цус олгохтой холбоотой мэдээллийг тогтмол өгч ажилласан. Үүнд: Үйлчлүүлэгчид өгсөн лавлагаа, зөвлөгөө, мэдээлэлийн бүртгэлийг хөтөлж, 2021 онд нийт 1431 зөвлөгөө, лавлагаа, мэдээллийг ард, иргэд, үйлчлүүлэгчид өгч ажилласны 1214 буюу 84% нь утас, 268 буюу 22 % нь амаар зөвлөгөө өгсөн байна. Нийт зөвлөгөөний 33% донорын тухай, 25% лаборатори, 16% ЦЦБ–ий захиалга, 26 % бусад мэдээлэл эзэлж байна.</p>
--	--	--	--	--	---

						<p>1. Гаднах талбайд эмнэлгийн машины зогсоол байгуулан таних тэмдэг тавьж байршуулсан. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг ханган гадна гэрэлтүүлгийг цагийн тохируулгатай тогтмол ажиллагаатай байлгах, шатны бариулуудыг будах, халтиргаа гулгаанаас сэргийлж гишгүүр байршуулах, бохир, цэвэр улавч ангилан ялгаж хийх зориулалтын хайрцаг санаачлан хийж ажиллалаа.</p> <p><b>Хавсрал.Төлөвлөгөө, тайлан</b></p>	
55	Авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	-	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Авилгын эсрэг хуулийн дагуу урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	<p>Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэн хамаарал бүхий 8 ажилтнаас ХАСХОМ гаргуулж, эхний улиралд 206 мэдэгдэл, тайлбар гаргуулан авч ажилласан.</p> <p>Шинэ ажилтны баримжаа олгох сургалтыг 3 удаа хамтран зохион байгуулж Эмнэлгийн ажилтны хариуцлага сэдвийн хүрээнд авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хичээл орсон.</p> <p>ХАСХОМ мэдүүлэхтэй холбоотой цахим сургалтад 2 удаа, Авилгатай тэмцэх үндэсний форумд 1 удаа тус тус цахимаар хамрагдсан.</p> <p>Авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 2021 оны төлөвлөгөөнд 35 ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн бөгөөд жилийн эцсийн байдлаар 100 хувийн гүйцэтгэлтэй байна.</p>	100 %

56	Төвийн сувилахуйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх ажлыг зохион байгуулна.	-	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Сувилахуйн албаны 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 7 зорилтын дагуу 17 ажил төлөвлөн 95% биелсэн.	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	<p>Сувилахуй, үйлчилгээний алба 2021 онд 6 зорилтын хүрээнд 21 ажлыг төлөвлөн захирлаар батлуулан 100% хэрэгжүүлэн ажиллаж байна. Төвийн коронавируст халдварын үед шаардлагатай хувийн хамгаалах хэрэгсэл нөөцийн мэдээг (burtgel.mohs.mn) 7 хоног тутамд тогтмол мэдээлдэг.</p> <p>-ЭМС-ын 2019 оны А/537 дугаар тушаалын 6-р хавсралтын дагуу СҮА, ДЗБТ, НЛ,ҮТ тасгуудын дунд 30 удаагийн ижил мэргэжилтний үнэлгээг зохион байгуулсан.</p> <p>-Төвийн үйл ажиллагаанд хэрэгжүүлж байгаа чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартын дагуу СҮА-ны Үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй 18 бичиг баримтуудыг шинэчлэн боловсруулсан.</p> <p>-Сувилахуйн мэргэжлийн “Тэргүүлэх”, “Ахлах” зэргийг 5 сувилагч хамгаалсан.</p> <p>-Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл лицензыг 7 сувилагч сунгуулсан.</p> <p>-Сургагч багшийн сургалтанд 2 сувилагч, чиглүүлэгч багшийн сургалтанд 1 сувилагч хамрагдсан.</p> <p>-Эрүүл мэндийн сайдын А/505 тоот тушаалын дагуу аюултай хог хаягдлыг устгах, зөвөлрөх үйл ажиллагааг Элемент ХХК-тай хамтран хэрэгжүүлдэг.</p> <p><b>Хавсралт.Төлөвлөгөө, тайлан</b></p>	100 %
57	<b>ТЭМТББ 2.5.2.1:</b> Халдварын сэргийлэлт хяналтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг хангаж ажиллана.	21.8	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	2020 онд 5 чиглэлээр 24 үйл ажиллагаа төлөвлөн, 100% хэрэгжүүлж ажилласан.	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжиж, халдвар хамгаалалтай холбоотой зөрчил гараагүй байна.	Халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээрх ЭМС-ын 2019 оны А/536, А/537, А/538, А/539 дугаар, 2017 оны А/505 дугаар тушаалын хэрэгжилтийг хангахаар төвийн үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн 2 журам, 3 стандарт ажиллагааны заавар, 3 ажлын заавар, 13	97,3 %

						<p>анхан шатны маягт боловсруулан баталж, нийт ажиллагсад мөрдөн ажиллаж байна. 2021 онд халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр хэрэгжүүлэх 6 чиглэл 30 заалт бүхий төлөвлөгөө гарган биелэлтийг ханган ажиллалаа. Төлөвлөгөөний хэрэгжилт 97,3% биелсэн.</p> <p><b>Хавсралт.Төлөвлөгөө, тайлан</b></p>	
58	Санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.	-	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	2020 оны аудитын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан.	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. Аудитын зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна.	<p>2021 онд санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах, санхүүгийн аудитын зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт бүрэн биелэсэн. Үүнд: 2020 оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах ажлыг хэсгийг ерөнхий захирлын А/06 дугаар тушаалаар байгуулж хяналт тавьж ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх 15 ажлын төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж, 6 сарын 3-нд тайланг үндэсний аудитын газарт хүргүүлсэн.</li> <li>• Эрүүл мэндийн яамны хяналт үнэлгээний газарт 2020 оны аудитын хэрэгжилтийн тайланг 9 сарын 4-нд хүргүүлсэн.</li> <li>• Шилэн дансанд 98 байгууллагын гэрээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил үйлчилгээний, санхүүжилтийн хэмжээгээр 3,289,198,716₮-ийн 15 мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш орлого 5,054,251,214, зарлагын 4,287,869,816₮-ийн 129 гүйлгээний мэдээлэлийг байршуулан байгууллагын</li> </ul>	

					<p>санхүүгийн самбар дээр мэдээллийг тогтмол шинэчлэн байршуулж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• 3 сарын 01-ний өдрөөс жижиг мөнгөн сангийн үлдэгдлийг 3,000,000 төгрөгөөс хэтрүүлэхгүй байлгаж байна. Цус, цусан бүтээгдэхүүний орлогыг 3 сарын 1-ээс эхлэн бэлэн бус хэлбэрээр буюу төвийн Хас банкн дахь дансаар хүлээн авч, төрийн санд төлөвлөрүүлж ажилласан. Төлбөрт үйлчилгээний орлого буюу шинжилгээний төлбөрийг дараа өдөрт нь багтаан Төрийн сан дахь дансанд байршуулан ажилласан.</li> <li>• Бэлэн мөнгөний тооллогыг сар бүрийн эцэст хийж баримтжуулж ажиллав.</li> <li>• Цусны доноруудын урамшууллын зардлыг 2 дугаар улирлаас эхлэн цусны доноруудад бэлэн мөнгө олгохгүйгээр ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын Цусны донор, донор зохион байгуулагч нарт урамшуулал олгох тухай 2021 оны А/09 дүгээр тушаал гарган хүнсний багц хэлбэрээр олгож байна.</li> <li>• Үндсэн хөрөнгийн тооллогын дүнг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцэн 2020 оны жилийн эцсийн тооллогоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг үнэлж, ашиглах боломжгүй хөрөнгийн жагсаалтыг үйлдэж ЭМЯ, ТӨБЗГ-т хүргүүлсэн. ТӨБЗГ-ын 5 сарын 20-ны өдрийн 155, 178 дугаар тогтоолууд гарч хэрэгжилтийг хангаж ажилласан.</li> </ul> <p><b>Хавсралт.Төлөвлөгөө, тайлан</b></p>	
--	--	--	--	--	---	--

59	Цус, цусан бүтээгдэхүүний өртгийг шинэчлэн тооцож, холбогдох байгууллагад хүргүүлнэ.	-	Шинэчлэн тооцсон бүтээгдэхүүний өртгийн тооцоо, санал	2017 онд бүтээгдэхүүний өртгийг тооцсон.	Үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний нэр төрлөөр өртгийг шинэчлэн тооцож холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	<p>Цус, цусан бүтээгдэхүүний өртөг тооцох, үнэ шинэчлэх талаар дараах арга хэмжээг авч ажилласан. Үүнд:</p> <p>ЦЦБ-ний хэрэглээ, лавлагаа шатлалын лабораторийн үзүүлж буй төлбөртэй шинжилгээний үнийг ЭМД-д хамруулах саналыг ЭМДЕГ, ЭМЯ-д тус тус хүргүүлсэн.</p> <p>ЦЦБ-ий үнийг шинэчлэх бэлтгэл ажлын хүрээнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зураглал, үе шатыг судлаж, тасгийн үйлдвэрлэлийн мэргэжсэн ажилтнуудаас мэдээлэл авсан.</p> <p>2017 оны өртөг үнийн тооцоог судалж, өртөг тооцох үйл ажиллагаанд ашигласан.</p> <p>2021 оны ЦЦБ-ий өртгийн тооцоог шууд зардлын аргаар тооцож үйлдвэрлэлийн тасаг, Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч, албаны дарга, ерөнхий захирлаас зөвөлгөө авч шаардлагатай засварыг хийж ЭМЯ-ны ажлын хэсэгт хүргүүлсэн эцэслэн батлагдаагүй хэлэлцэгдэж байна.</p> <p>Лабораторийн төлбөртэй тусламж үйлчилгээний бодит өртгийг тооцсон.</p> <p>SARS-COV-2 эсрэг бие агуулсан эмгэгтөрөгүүлэгчийг идэвхигүйжүүлсэн сийвэнгийн нэгжийн үнэ 250000 төгрөг, SARS-COV-2 эсрэг бие агуулсан сийвэнгийн нэгжийн үнэ 140000 төгрөг байхаар тус тус шийдвэрлэж захирлын тушаалаар баталгаажуулан мөрдөж байна.</p> <p><b>Хавсралт. Үнийн санал</b></p>	100 %
----	--	---	---	--	--	--	-------



Төлөвлөгөөг хянасан:  
**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД**  
**С.ЭНХБОЛД**

(албан тушаал)

Төсвийн Ерөнхийлөн захирагч

.....  
(гарын үсэг)

.....  
(огноо)

Тэмдэг

Төлөвлөгөөг тайлагнасан:  
**ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ**  
**Н.ЭРДЭНЭБАЯР**

(албан тушаал)

Төсвийн Шууд захирагч

.....  
(гарын үсэг)

.....  
(огноо)

Тэмдэг

